

10 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл: Аймгийн Засаг дарга Ж. Эрдэнэбаатар 2019 оны 10 сарын 09-нд "Сүхбаатар аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилт"-ын төслийг аймгийн ИТХ-ын дарга Б. Мөнхбатад өргөн барилаа.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/565-р захирамжаар томилогдсон хяналт шинжилгээ үнэлгээний ажлын хэсэг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, албад болон төсөвт байгууллагуудын 2019 оны үйл ажиллагаанд газар дээр нь хяналт шинжилгээ хийж, зөвлөн туслаж ажиллалаа.

Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/ мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан уг хуулийн үзэл санаанд нийцүүлэн төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлөөр хянуулж, батлуулах үүрэг бүхий ажлын хэсэг томилогдон Төрийн албаны зөвлөлөөс арга зүйн зөвлөгөө аван Улаанбаатар хотод ажиллаж байна. Ажлын хэсэг төрийн захиргааны 10 байгууллагын 140 албан тушаалд хамаарах 113 албан тушаалын тодорхойлолтыг хянуулсанаас 9 байгууллагын 99 албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлөөр батлуулаад байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс “Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй” сургалтыг зохион байгуулж агентлаг, албад төсөвт байгууллагын 56 албан хаагчийг хамрууллаа.

Хоёр. Хууль, эрх зүйн хүрээнд

Аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэс, Удирлагын академийн дэргэдэх Компанийн засаглалын Үндэсний зөвлөлтэй хамтран “Компанийн засаглалын гэрчилгээ олгох” сургалтыг зохион байгууллаа. Уг сургалтад 30 хүн хамрагдаж гэрчилгээгээ гардан авсан ба компанийн засаглалыг сайжруулж, ашиг орлого нэмэгдэх, хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулагчдын идэвхи сонирхолыг нэмэгдүүлэх, гарч болох эрсдэлийн талаарх ойлголт, мэдээллийг авсан байна.

Тус хэлтэс Авлигатай тэмцэх газартай хамтран иргэд олон нийтэд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэдийг татан оролцуулах, зөвлөгөө, мэдээлэл өгөх, гомдол хүлээн авах, санал, хүсэлтийг сонсох зорилгоор Иргэн төвтэй соён гэгээрүүлэх өдөрлөгийг 10 дугаар сарын 21-ний өдөр зохион байгууллаа. Энэ үеэр авлигатай тэмцэх чиглэлээр иргэний үүрэг оролцоо ямар байх, төрийн албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлэгийн ил тод байдал, хяналт тавих боломжийн талаар мэдээлэл өгч, иргэдийн сонирхсон асуултад хариулж, гомдол хүлээн авав. Авлигатай тэмцэх газрын гомдол, мэдээлэл хүлээн авах утас 110 дугаарын утсыг иргэд олон нийтэд таниулан сурталчлах, иргэдийн дунд асуулт хариултын хөгжөөнд АХА тэмцээн зохион байгуулах зэрэг арга хэмжээг зохион байгуулсан.

Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрөл олгох, сунгах, хяналт тавих ажлын талаарх 87 хуудас материалыг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэв.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/559 дүгээр захирамжаар 3 аж ахуй нэгжид согтууруулах ундаа худалдах, 2 аж ахуй нэгжид согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгосон.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргын батласан удирдамжийн дагуу сумдын ГХУСАЗСалбар зөвлөлийн үйл ажиллагаанд зөвлөн туслах ажлаар аймгийн ИТХ, АЗДТГ, Аймгийн Прокурорын газар, Шүүх, Цагдаагийн газрын хамтарсан ажлын хэсэг Уулбаян, Түвшинширээ, Мөнххаан, Түмэнцогт, Сүхбаатар сумдад 10 дугаар сарын 22-ноос 5 хоног ажилласан.

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас “Ахмад настан хэрэглэгч” аян зохион байгуулсантай холбогдуулан ШӨХТГ-ын орон нутаг дахь орон тооны бус улсын байцаагч, Нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Стандарт хэмжил зүйн

хэлтэс, Худалдаа эрхлэгчдийн төрийн бус байгууллага, ахмадын хороотой хамтран сургалт зохион байгуулж 40 гаруй ахмад настанг хамрууллаа.

Аймгийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуй нэгжүүдэд хяналт шалгалт, аттестачилал явуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2019 оны А/598 дугаар захирамжаар байгуулан, батлагдсан удирдамжийн дагуу 10 дугаар сарын 22-ны өдрөөс хяналт шалгалтын ажлыг Баруун-Урт сумын нутаг дэвсгэрт согтууруулах ундаагаар үйлчилдэг аж ахуй нэгжүүдээс эхлэн зохион байгуулж байна.

Архив: Иргэд хөдөлмөрчдөөс амаар болон бичгээр нийт 63 өргөдөл хүлээн авч шийдвэрлснээс Лавлагаа 38, хуулбар 37 иргэнд олгож давхардсан тоогоор 560 гаруй хадгаламжийн нэгжээр үйлчилсэн. Цахимд 4303 хуудас баримтыг скайнердаж, photoshop-оор засварлаж, 1295 хуудас баримтыг программд шивж оруулаад байна.

Нөхөн бүрдүүлэлтээр Баруун-Урт сумын 4-р багт хүүхдийн тоглоомын талбай, Баруун-Урт сумын төвд баригдсан төмс хүнсний ногооны зоорийн барилга, Авто болон ахуйн баллон хийгээр цэнэглэх станцын барилгын зураг төслийн 15 хадгаламжийн нэгж хүлээн аваад байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар: Хорихоос өөр төрлийн ялын 399 гүйцэтгэх баримт бичиг шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулснаас 271 гүйцэтгэх баримт бичгийг дуусгавар болгосон.

Торгох ялын 132 гүйцэтгэх баримт бичгийн 117794,0 мянган төгрөгөөс 121 гүйцэтгэх баримт бичгийн 82824,0 төгрөгийг биелүүлж, хугацааны хэтэрсэн торгох ял байхгүй байна.

Иргэн, Эрүүгийн нийт 1165 гүйцэтгэх баримт бичгийн 3,013,175,850 төгрөгийн төлбөр тэтгэлгийн материалд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулан ажилласнаас, орон нутгийн орлогод 2019 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар 63,488,337 төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд 2019 оны 10 дугаар сард биелүүлбэл зохих 469 гүйцэтгэх баримт бичгийн 2,476,568.7 мянган төгрөгийн төлбөрөөс 283 гүйцэтгэх баримт бичгийн 606,349.7 мянган төгрөгийг бодитой биелүүлж, бодит биелэлт өмнөх оны мөн үеэс 60,3 хувь буюу 0,3 хувиар өссөн үзүүлэлтэй байна.

Төрийн байгууллагын нэхэмжлэлтэй гүйцэтгэх баримт бичгийн биелүүлбэл зохих 126 гүйцэтгэх баримт бичгийн 150,854.5 мянган төгрөгийн төлбөрөөс 115 гүйцэтгэх баримт бичгийн 115,022.1 мянган төгрөгийг биелүүлж, бодит биелэлт өнгөрсөн оны мөн үеэс 91 хувь буюу 13,5 хувиар өссөн байна.

2019 оны 10-р сарын байдлаар сум хөгжүүлэх сангийн зээлийн холбоотой 25 гүйцэтгэх баримт бичгийн 242,549,5 мянган төгрөгийн материалд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж, 5 гүйцэтгэх баримт бичгийн 24,673,9 мянган төгрөгийг хэсэгчлэн, 7 гүйцэтгэх баримт бичгийн 66,981,8 мянган төгрөгийг дуусгавар болгон, нийт 91,655,7 мянган төгрөгийг төлүүлсэн.

Шүүхийн шинжилгээний алба : Албаны бие бүрэлдэхүүн Цагдаагийн газрын шуурхай албаны бүрэлдэхүүнд орж ажиллан жижүүрт 30 удаа гарч ажилласнаас хүний амь нас хохирсон хэргийн дуудлаганд 7 удаа, хулгайн хэргийн дуудлаганд 7 удаа, зам тээврийн ослын дуудлаганд 4, бусад хэргийн дуудлаганд 1 удаа, нийт 19 хэргийн газрын үзлэгт оролцон хэргийн газрын үзлэгээр гутлын мөр 0 ширхэг, гарын мөр 9 ширхэг, тээврийн хэрэгслийн мөр 9 ширхэг, бусад ул мөр 51 ширхэг, ул мөр илрээгүй үзлэгийн тоо 9 ширхэг нийт 78 ул мөр илрүүлж, бэхжүүлэн хураан авлаа.

10-р сарын байдлаар хүний биед гэмтлийн зэрэг тогтоох үзлэг 48 удаа хийснээс хүнд-1, хүндэвтэр-4, хөнгөн-21, гэмтлийн зэрэгт хамаарахгүй-10, гэмтлийн зэрэг тогтоогдоогүй-12 дүгнэлт гаргасан байна. Бэлгийн маргаантай хэргийн дүгнэлт гаргаагүй байна. Гэмт хэргийн болон бусад шалтгаанаар нас барсан 6 хүнд шүүх эмнэлгийн задлан шинжилгээ хийж дүгнэлт гаргалаа. Мөн задлан шинжилгээний явцад цогцосноос эд эрхтэний дээж материал болон цусан дахь этилийн спиртын хувь хэмжээг тодорхойлох зорилгоор заавар журмын дагуу дээж материалыг авч, лабораторит химийн 12 шинжилгээ хийж дүгнэлт гаргалаа.

Улсын бүртгэлийн хэлтэс: Монгол улс бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд шилжсэний 10 жилийн ойн хүрээнд Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс энэ сарын 26-ны өдөр 3үүн

бүс худалдааны төвд "Нээлттэй өдөрлөг" амжилттай зохион байгуулж 70 гаруй иргэнд мэдээ мэдээлэл өгсөн.

Гурав. Нийгмийн бодлогын хүрээнд

Боловсролын чиглэлээр: Азиа Монголиа Төрийн бус байгууллагын санхүүжилтээр Асгат сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны дээврийн болон дотор завсар, гал зуухны өргөтгөл ус цэвэршүүлэх байгууламж шинээр тавих ажил хийгдэж ашиглалтанд орлоо.

Туркийн Тика хөтөлбөрийн санхүүжилтээр хийгдэж байгаа Түмэнцогт сумын цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажил дуусч ашиглалтанд ороход бэлэн болсон.

Монгол улсын Гамшигаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хүүхэд өсвөр үеийнхэнд сурталчлах зорилгоор аймгийн болон зүүн бүсийн аварга шалгаруулах "Өсвөрийн аврагч-2019" тэмцээнийг аймгийн Онцгой байдлын газартай хамтран зохион байгууллаа. Тус тэмцээнд Сүхбаатар аймгийн баг түрүүлэн, улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцон дэд байр эзэллээ.

Дэлхийн болон Монголын багш нарын баярын өдрийг тохиолдуулан БСУГ-ын хамт олон "Багшдаа баярлалаа" концертыг тоглож, баярын хурлын үеэр Засгийн газрын болон БСШУСЯ, аймаг сумын ИТХ, ЗД-ын шагналаар багш нараа шагнаж урамшууллаа. Мөн Баруун Урт сумын ЕБС-уудын багш нарын дунд Гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулагдлаа.

Монгол Улсын Их хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, БСШУССайд Ё.Баатарбилэг Сүхбаатар аймагт ажиллан Баруун-Урт сумын боловсрол соёлын байгууллагуудын ажилтнуудтай уулзалт хийж, Халзан суманд баригдаж буй соёлын төв, цэцэрлэгийн барилгын ажлын явцтай танилцлаа.

БСУГ-ын зөвлөн туслах ажлын хэсэг Баяндэлгэр, Түвшинширээ, Уулбаян сумдын боловсрол соёлын байгууллагуудад ажиллалаа.

2018-2019 оны хөрөнгө оруулалтын ажлууд хийгдэж байгаатай холбогдуулан Сүхбаатар сумын ЕБС-ийн их засвар, Халзан сумын Хүүхдийн цэцэрлэг, соёлын төв, Түвшинширээ сумын Соёлын төв, Хүүхдийн цэцэрлэг, Уулбаян сумын дотуур байр, соёлын төвийн барилгын үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцаж, гүйцэтгэгч ХХК-удын удирдлагуудад аймгийн Засаг дарга Ж.Эрдэнэбаатар үүрэг чиглэл өглөө.

"ЕБС-ийн Сургалтын менежер, цэцэрлэгийн арга зүйчийн манлайлах ур чадвар, менежментийн чадавхийг дээшлүүлэх, багшид мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлын чанарыг сайжруулах" зорилгоор БСШУСЯ, Боловсролын үнэлгээний төв, Боловсролын хүрээлэнгээс Дорнод аймагт зохион байгуулсан зөвлөгөөнд Ерөнхий боловсролын 16 сургуулийн сургалтын менежер, 24 цэцэрлэгийн арга зүйч, Боловсрол соёл урлагийн газрын мэргэжилтэн нийт 56 хүн оролцлоо.

БСШУСЯ, Боловсролын үнэлгээний төв, Боловсролын хүрээлэнгээс зохион байгуулсан Үнэлгээний шинжээч багш бэлтгэх сургалтанд 3 хүн оролцож сургагч багшаар бэлтгэгдэж, БСШУСЯ, Монголын эмэгтэйчүүдийн хөгжлийн сан хамтран зохион байгуулсан "Бага насны хүүхдийг хүчирхийллээс хамгаалах мэдлэг чадвар олгох" сургалтад 3 багш оролцож мэдлэг чадвараа дээшлүүллээ.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр:

Гэр бүлийн нэгжийн хүрээнд: Гэр бүлийг дэмжих туршилтын хөтөлбөрт хамрагдсан өрхүүдийн 2 дахь удаагийн нөхцөл байдлын үнэлгээг хийж ажилласан.

АА Нийгэмлэгтэй хамтран сургалт зохион байгуулж архианаас гарах хүсэлтэй 5 иргэнийг архианаас гаргах эмчилгээнд хамруулахаар болов.

Аймгийн төвийн 11 цэцэрлэгийн эцэг эхчүүдэд цэцэрлэг бүр дээр очиж "Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга сургалтыг зохин байгуулсан. Сургалтад 458 эцэг эх хамрагдсан байна.

Хүүхдийн нэгжийн хүрээнд: Дэлхийн болон Монголын хүүхдийн шилдэг зохиол бүтээлийг хүүхэд багачуудад таниулах, сурталчлах, номонд дуртай болгох, номтой нөхөрлүүлэх, тэдний дунд уран уншлагын урлагийг дэлгэрүүлэх, авъяасыг нээн хөгжүүлэх, хүүхдүүдэд бие биеэсээ суралцах боломжийг олгох зорилготой "Уран жиргээ"-2019 хүүхдийн уран уншлагын

тэмцээнийг зохион байгуулж 4 төрлөөр шалгаруулалт хийсэн ба аймаг, сумын сургууль, цэцэрлэгийн 77 авъяаслаг уран уншигчид оролцлоо.

Өсвөр үеийн хүүхдийн хөгжил оролцоог дэмжих, эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, бэлгийн болон нөхөн үржихүйн талаар мэдээлэл өгөх зорилгоор “Хөгжсөн хүүхэд хамгаалагдана” зөвлөгөөнийг зохион байгууллаа. Уг уулзалт зөвлөгөөнд Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын “Боловсрол өргөө” дотуур байранд амьдардаг ахлах ангийн 114 сурагч хамрагдлаа. Сургалтын үеэр тэдэнд “Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн замын халдварт өвчнөөс сэргийлэх” “Хорт зуршил” “Хүүхдийн эрх хамгаалал” “Аюулгүй байдлын дүрэм” сэдвүүдээр өртөөчилсөн байдлаар хөгжилтэй тоглоомын аргаар мэдээлэл өгсөн.

“Охидын эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан ЕБС-ийн 16 сургууль, хүүхэд хамгааллын жишиг сургууль, МСҮТ-ийн оролцооны байгууллага, охидын клубын ахлах ангийн төлөөлөл болсон 90 гаруй охидод “ОХИДЫН ЭРХ”-ийн талаарх мэдээллийг хүргэж, хүүхдийн хөгжил оролцооны байгууллагын 113 өсвөр үе сурагчид өөрийн үйл ажиллагаатай холбоотой сонирхсон чиглэлээр 2 сарын хугацаатай хэрэгжүүлэх төслийн чиглэлийг танилцуулсан. Мөн “Бидний шивнээ-Таны итгэл” сэдэвт дотно ярилцлагыг зохион байгуулж тэдэнд тулгамдаж буй асуудлыг гаргаж, шийдвэрлэх арга замыг тодорхойлон ярилцлаа. Уг арга хэмжээний үеэр МСҮТ-ийн багш, оюутнуудтай хамтран охидод гоо зүйн боловсрол олгох чиглэлээр гоо сайхны үйлчилгээ үзүүлж, өсвөр үеийнхний хувцаслалт, биеэ авч явах талаар зөвлөгөө мэдээллийг хүргэлээ.

Сүхбаатар аймгийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо хуралдаж аймгийн хэмжээнд хүүхэд оролцож үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил, хүүхдийн эсрэг гэмт хэргийн өнөөгийн байдал, хийж гүйцэтгэсэн ажлын танилцуулга, төлөвлөгөөний биелэлттэй танилцаж, гэмт хэрэг, зөрчилд хүүхэд холбогдохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг зохицуулах талаар санал солилцож цаашид хэрэгжүүлэх ажлын чиглэлийн талаар ярилцлаа.

Хүүхдийн эрхийн зөрчлийн холбогдолтой 2 кейсийг хүлээн авч бүртгэн эрүүл мэндийн болон нийгэм сэтгэлзүйн бусад шаардлагатай үйлчилгээ байгаа эсэхэд үнэлгээ хийн ажиллаж байна.

Залуучуудын нэгжийн хүрээнд: Боловсрол өргөө нэгдсэн дотуур байрын сурагчдад Цахим донтолт, Хорт зуршил сэдвээр захилгат сургалтыг зохион байгуулж 128 сурагчийг хамрууллаа.

“Аавууд нэг өдөр” телевизийн нэвтрүүлгийг хийж орон нутгийн ТВ болон сошиал мэдээллээр олон нийтэд хүргээд байна.

Өсвөр насны хүүхдүүдэд ирээдүйд эзэмших мэргэжлээ зөв сонгохтой холбоотой мэдээлэл өгөх, ахлах ангийн сурагчдад эрсдэлээс урьдчилан сэргийлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, мэргэжил сонголтод арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор ЕБС-ийн 12 дугаар ангид “Ирээдүйн эзэд” мэргэжил сонголтын аян, МСҮТ-ийн суралцагчдад “Эерэг хандлага-Эрүүл оюутан” аяны хүрээнд сургалт зохион байгуулсан. “ИРЭЭДҮЙН ЭЗЭД” мэргэжил сонголтын аяны хүрээнд зохион байгуулагдсан сургалтад ЕБС-ийн 12 дугаар ангийн 271 сурагч, “Эерэг хандлага- Эрүүл оюутан” аяны хүрээнд зохион байгуулагдсан сургалтад 76 сураглцагчид тус тус хамрагдсан. Уг үйл ажиллагаанд аймгийн төвийн 4 сургуулийн ЕБС-ийн ахлах ангийн сурагчид МСҮТ-ийн суралцагчид нийт 347 хүүхэд хамрагдлаа.

Соёл урлагийн чиглэлээр:

Нийтийн номын сан: Уншлага үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад анхаарч 2019 үйлчилгээндээ “Үүлэн технологи” нэвтрүүлэн ажиллаж Номын сангийн Lib4U программ хангамж мэдээллийн бааз онлайн орчинд ажиллаж байгаа бөгөөд номын сангийн үйлчилгээг цахим хэлбэрээр явуулж хэвшсэн. Байнгын уншигч 1217, Ирэгсэд 4772, Ном олголт 10219 байна.

Уншигчдаас эрэлт хэрэгцээт номын захиалга авч, төсвөөр 2424936 төгрөгний 123 төрлийн 217 ширхэг ном, хандиваар 675500 төгрөгний 56 нэр төрлийн 70 ширхэг нийт 3100436 төгрөгний 179 нэр төрлийн 287 ш номоор фондоо баяжуулсан.

Зөөврийн номын сангийн үйлчилгээг 10 дугаар сард 11-р цэцэрлэгийн хөгжлийн бэрхшээлтэй ангид тэдний нас сэтгэхүйд тохирсон хүрч мэдрэх, харж ойлгоход зориулсан 10 ном, мөн цахим номын хамт хүргэж ажилласан байна.

Хараагүй Хүмүүсийн Инноваци Хөгжлийн Төв ТББ, Канад сангаас санхүүжүүлэн ХХИХТөвөөс хэрэгжүүлж буй "Харааны бэрхшээлтэй иргэдийг мэдээлэл харилцааны шинэ технологиор дамжуулан чадваржуулах нь" төсөл хэрэгжиж, иж бүрэн компьютер 2, сканнер 1, дэйзи цахим ном тоглуулагч 3, брайль орбит төхөөрөмж 2 зэрэг нийт 46 сая төгрөгний техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдлаа. Түүнчлэн уг төслийн хүрээнд "Орбит брайль төхөөрөмжийн сургалт, харааны болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэлгэц уншигч программын сургалт, Харааны болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гэр бүлийн гишүүдэд зориулсан сургалтыг Инноваци хөгжлийн төвийн төслөөс зохион байгуулж 120 гаруй хөгжлийн боошээлтэй иргэдийг хамруулсан байна.

Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигийн хэрэгжилтийг ханган Номын баяр-Бидний баяр арга хэмжээг аймгийн зохион байгууллаа. Номын баярт 13 сумын 16 сумын сургууль, сумын номын сан эцэг эхийн хамтарсан баг оролцон зохиолч сэтгүүлч Я.Түмэннастын "Сүхбаатар аймгийн Түүхэн товчоо" номоор бүтээл хийж өрсөлдлөө. Энэхүү эрга хэмжээнд сум, сургуулийн номын санч, багш сурагчдын төлөөлөл болох 120 гаруй хүн оролцлоо.

Хөгжимт жүжгийн театр: Жаахан шарга театрын бүжигчин МУСТА Л.Ган-Эрдэнэ "ETHNIC DANCE" тоглолтоо зохион байгууллаа.

"ХОС УЯНГА" хослон дуулаачдын уралдааныг аймгийн хэмжээнд зохион байгууллаа.

"Үл тасрах есөн эрдэнэ" тоглолтоо хийсэн есөн сайхан уран бүтээлчийнхээ Жаахан шарга театраас ажил ажил амьдралынхаа гарааг эхэлж байсан. Ц.Ганбат, Ц.Ганзориг нартаа хүндэтгэл үзүүллээ.

Төрийн шагналт Ч.Чимэдийн зохиол, МУСТА З.Далай найруулгаар "МАШ НУУЦ" жүжиг нээлтээ хийлээ.

ХЖТ-ын дуучдын "Таван улирлын өнгө" тоглолт зохион байгуулж үзэгч олондоо хүргэсэний зэрэгцээ Сүхбаатар сумын иргэдэд толилууллаа.

Угсаатны зүйн музей: Төр нийгмийн зүтгэлтэн Ц.Жинжиджавын танхимыг нээлээ.

Угсаатны зүйн музей байгуулагдсны 70 жилийн ойг тэмдэглэн "Сүхбаатарын өв соёл" үзэсгэлэн, эрдэм шинжилгээний хурал зохион байгууллаа.

Эрүүл мэндийн чиглэлээр: Эх, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламжийн чанарыг сайжруулах багийг 5 суманд ажиллуулж 6-36 сартай 108 хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагчдад эрүүл мэндийн болон хүүхдийн хоол бэлтгэх дадлага сургалтыг зохион байгуулж зардлыг аймгийн Засаг даргын нөөц сангаас гаргалаа.

Монгол Улсад Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй "Нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх нь" төслийн хүрээнд "Өсвөр үеийнхний шүдний өвчлөлийг бууруулах нь" дэд төсөл 8 суманд хэрэгжиж төслийн үр дүнгийн уулзалтыг төслийн багтай хамтран зохион байгууллаа. Уг арга хэмжээнд төсөл хэрэгжүүлэгчид, оролцогчид өөрсдийн туршлагаа хуваалцаж цаашид тогтвортой байлгах талаар саналаа солилцлоо.

Халзан, Онгон, Дарьганга, Уулбаян сумдад Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг явуулын хэлбэрээр үзүүлж давхардсан тоогоор 3174 иргэнийг хамрууллаа.

Нийгмийн даатгалын Ерөнхий газартай хамтран Үйлдвэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн сургалтыг ААН, байгууллагуудын удирдлага, ХАБ хариуцсан ажилтан нийт 85 хүнийг хамруулан явуулж сертификат олголоо.

Дархлаажуулалтын 10 хоногийн аяныг "Томуугаас сэргийлье"уриан дор зохион байгуулж, аймгийн хэмжээнд 2050 хүн тун томуугийн вакциныг татан авч, зорилтот бүлгийн хүн ам буюу, жирэмсэн эмэгтэйчүүд, 65-аас дээш насныхан, архаг суурь өвчтэй хүн болон эрүүл мэндийн байгууллагын ажилтан, сайн дурын дархлаажуулалтанд хамрагдах хүмүүст хийлээ.

Азийн хөгжлийн банкны 16 сая төгрөгийн санхүүжилтээр ЭМЯ, ХӨСҮТ-тэй хамтран 2 багц цагийн "Вируст гепатитын оношилгоо, илрүүлэг, урьдчилан сэргийлэлт, эмчилгээний

чадавхийг сайжруулах”сургалтыг зохион байгуулж АНЭ, сум дундын эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эмнэлгүүдийн нийт 66 эмч, лаборант, халдвар хамгааллын ажилчдыг хамруулж, ЭМЯ-д сургалтад хамрагдсан 16 их эмчид В, С вирусийн эм бичих эрх олгох хүсэлтийг хүргүүлээд байна.

Дэлхийн гар угаах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх 4 чиглэл бүхий удирдамж, 5 үйл ажиллагаа бүхий төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж цэцэрлэг болон сургуулийн бага бүлгийн 408 хүүхдийг сургалтад хамрууллаа.


Онгон сум дундын эмнэлэгт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар фургон маркийн автомашин олгогдсоноор тус сумын иргэд эрүүл мэндийн үйлчилгээг түргэн шуурхай авах боломжтой боллоо.

Давсны хэрэглээг бууруулах үндэсний стратеги, Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих ажлын хүрээнд 13 сумдыг 3 бүсэд хувааж, Дарьганга бүсийг 10 дугаар сарын 04-6-нд, Баяндэлгэр, Мөнххаан бүсийг 10 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд Тогооч нарын ур чадварын уралдаан, сургалтыг АЗДТГазар, ХХААГазар, СХЗХэлтэстэй хамтран зохион байгуулав.

Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилттэй “Цэвэр зүрх” төслийн хүрээнд Баруун-Урт сумын 3, 9 дүгээр цэцэрлэгийн нийт 259/240/92.6% хүүхдийн ясны сийрэгжилтийг тодорхойлж, эцэг эхчүүдээс асуумж судалгаа авч үр дүнг боловсруулан ажиллаж байна.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын чиглэлээр:

Хөдөлмөр эрхлэлтийн талаар: 2019 оны 10-р сарын байдлаар хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй ажил хайгч 960 иргэнээс эмэгтэй 449, бүртгэлтэй ажилгүй иргэн 731 иргэнээс, эмэгтэй 338 иргэн байна. 781 ажлын байрны захиалга бүртгэгдэж, 651 иргэнийг ажилд зуучилсан байна. Ажилд зуучлагдсан иргэдийн 381 иргэн буюу 58,5% нь байнгын ажлын байртай болсон байна. Шинээр бий болсон 682 ажлын байрны мэдээллийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.



ХЗЗ-н мэдээллийн нэгдсэн санд 62 иргэнийг шинээр болон сэргээн ажил хайгчаар бүртгэж, 17 иргэний ажилгүйдлийн тэтгэмжийн тодорхойлолтыг нийгмийн даатгалын хэлтэст гарган өгсөн.

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй 12 аж ахуйн нэгж байгууллагын 434 гадаад/хятад/, 1 солонгос ажилтныг монгол улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгоход байгуулгын зүгээс дэмжих саналыг олгож, хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан.

ЗДТГазар, Ажил олгогч эздийн холбоо, Онгон сумын ЗДТГазартай хамтран “Ажил олгогч, бизнес эрхлэгчидийн бүсчилсэн зөвлөгөөн”-г Онгон суманд 2019 оны 10-р сарын 17-нд зохион байгуулсан. Зөвлөгөөнд Онгон, Наран, Баяндэлгэр, Халзан, Дарьганга сумдуудын 72 бизнес эрхлэгч, ажил олгогчид, төрийн байгууллагын төлөөллүүд оролцлоо. Сургалтын хөтөлбөрийн дагуу АЗДТГазар, ХХҮГ, АОЭХолбооны мэдээллүүд тавигдаж, сум бүрт хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх талаар болон тулгамдаж буй хүндрэл бэрхшээл, гарах арга зам гэх мэт сэдвүүдээр, хэлэлцүүлэг зохион байгуулж, гарсан саналыг дүгнэж ярилцлаа. Мөн сумдын зөвлөгөөнд оролцогч бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, 4,6 сая төгрөгийн борлуулт хийгдэж, арга хэмжээ үр дүнтэй амжилттай зохион байгуулагдлаа.

Зээлийн дараах аж ахуй эрхлэлтийн сургалтыг “Залуу манлайлал хөдөлмөр хүний нөөцийн академи”-н сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулж 37 иргэн сургалтанд хамрагдсан. Мөн “Оюуны язгуур” сургалтын байгууллагатай хамтран хөдөлмөрт бэлтгэх сургалтыг зохион байгуулж зорилтод бүлгийн 59 иргэн, МСҮТ-тэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй 11 иргэнийг оёдолын мэргэжил олгох сургалтанд тус тус хамруулсан.

Хугацаат цэргийн алба хааж ирсэн 119 цэрэгт Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн танилцуулга болон ажил мэргэжлийн чиг баримжааны талаар зөвлөгөө өгсөн.

ХНХЯ-ны сайдын баталсан удирдамжийн дагуу ХАБЭА-н хуулийн хэрэгжилтийн улсын үзлэгийг уул уурхайн салбарт зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2019 оны А/578 дугаар захирамжаар 8 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан ба уг ажлын хэсэг Сүхбаатар, Түмэнцогт, Эрдэнэцагаан суманд үйл ажиллагаа явуулж буй уул уурхайд үзлэг хийж эхлээд байна.

Орон нутгийн санаачилгын төсөлд шалгарсан иргэдэд аж ахуй эрхлэлтийн сургалтыг 5 хоногийн хугацаатайгаар явуулж байна.

Нийгмийн халамжийн талаар: 2019 оны 10-р сард 13 сумын 87 иргэний нийгмийн халамжийн тэтгэмж, 29 иргэний тэтгэвэр, 159 иргэний ахмадын хөнгөлөлт, 74 хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, 0-3 насны хүүхдээ асарч байгаа эхийн 79 хувийн хэрэг, 91 иргэний жирэмсэн эхийн хувийн хэргийг хүлээн авч хянан баталгаажуулж нийгмийн халамж үйлчилгээний мэдээллийн системд баталгаажуулсан. Сумдын мэргэжилтнүүдээс тэтгэвэр тэтгэмж хөнгөлөлт тусламж авах 131 иргэдийн жагсаалтыг авч WAIS программд баталгаажуулалтыг хийсэн. 91 иргэний тэтгэвэр тэтгэмжийн нөхөн олголтын жагсаалтыг баталгаажуулан авч / WAIS / программд нэмж баталгаажуулсан.

2019 оны 10 дугаар сард олгох 1240 иргэний 210,534,760 мянган төгрөгийн тэтгэвэр, 1203 иргэний 111,756,600 мянган төгрөгийн тэтгэмж, 87 иргэний 10,270,750 мянган төгрөгийн ахмадын хөнгөлөлт, 258 иргэний 12,346,380 мянган төгрөгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, 671 иргэний 23,469,580 мянган төгрөгийн жирэмсэн эхийн тэтгэмж, 16 иргэний 2,574,000 төгрөгийн алдар цолтой ахмадын хөнгөлөлт, 3197 иргэний 156,834,690 мянган төгрөгийн 0-3 хүртэлх насны хүүхэд асарсаны тэтгэмжийн жагсаалт гарган банкинд илгээсэн.

Ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд шаардлагатай байгаа 7 ширхэг тэргэнцэр, хөтөвч суултуур 6 ширхэг, нурууны бүс 11 ширхэг, өвдгөвч 11 ширхэг, суга таяг 1 ширхэг, алхуулагч 1 ширхэг, гар таяг 11 ширхэг зэрэг тусгай хэрэгслийг захиалгаар аван иргэдэд хүлээлгэн өгсөн.

Зорилтот өрхийн сургууль, цэцэрлэгт суралцдаг хүүхдүүдийн сургалтын хэрэгцээг хангах, нийгмийн идэвх оролцоог сайжруулах зорилготой “Нэг өрхөд – Нэг дүрэмт хувцас аян” – ыг зохион байгуулж 82 хүүхдэд 2,236,500 төгрөгийн дүрэмт болон хичээлийн хэрэгсэл гардуулж ажиллалаа.

Ахмадын баярыг тохиолдуулан аж ахуйн нэгж, албан байгууллагын харъяалалгүй 3922 ахмадад 39220,0 мянган төгрөгийн хүндэтгэлийг үзүүлэв. Үүнээс Баруун-Урт сумын 1150 ахмадад 11500,0 мянган төгрөгийн хүндэтгэлийг үзүүлсэн.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дэргэдэх ахмадын амралт, сувиллын 21, 22-р ээлжинд нийт 37 ахмад настан амарсан. Амрагч нарт бариа засал, сэргээн засах физик эмчилгээ, хаш чулуун ор, шарлага, бумба, зөгийн балны татлага зэрэг эмчилгээ үйлчилгээг үзүүлсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь 10 сард 2 удаа хуралдаж 27 хүүхэд орж 22 хүүхэд асаргаа сунгагдаж, 5 хүүхэд асаргаа шинээр тогтоосон.

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар нь аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хүүхдээ асарч буй иргэдэд асаргааны сургалтыг зохион байгуулж 100 гаруй асран хамгаалагчийг оролцууллаа. Асарч буй иргэдэд урилга тараан өрхөөр зочлон биеийн байдалтай танилцаж суултуур шаардлагатай 2 иргэнд суултуур олгох асуудлыг

газар дээр нь шийдвэрлэж өглөө. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэний асран хамгаалагч 100 хүнд нийгмийн халамжийн тухай хууль, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль зэргээр мэдээлэл хийж ажиллалаа.

Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааг Баруун-Урт сумын 12 өрхөд хийж судалгааг мэдээллийн санд бүртгэж оруулсан.

Баруун-Урт сумын 5,7 дугаар багийн хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг өрхүүдэд үйлчилгээ үзүүлж буй Ц.Үүрцайх захиралтай "Чандмань дэлгэр ундрах" ХХК нь зорилтод бүлгийн 6 өрхийн 7 сурагчдад 360000 төгрөгний дүрэмт хувцас гардууллаа.

Авилгатай тэмцэх газраас иргэд олон нийтэд авилгын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авилгатай тэмцэх үйл ажиллагаанд иргэдийг татан оролцуулах, зөвлөгөө мэдээлэл өгөх, санал хүсэлтийг сонсох зорилгоор "НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ"-ийг 10 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулах үеэр иргэдэд нийгмийн халамжийн хуулийн мэдээлэл өгч, гарын авлага тарааж оролцлоо.

Дөрөв. Хөгжлийн бодлого төлөвлөлт, дэд бүтэц, хүнс, хөдөө аж ахуй, газар тариалан, зам тээвэр, уул уурхайн хүрээнд:

Аймгийн төвийн ус дулааныг хариуцдаг "Дөрвөлж" ОНӨҮГ-ын өвөлжилтийн бэлтгэл 90 орчим хувьтай байна. Баруун-Урт сумын нийт хэрэглэгчдийн 75 хувийг дулаанаар хангадаг дулааны станцын хоёр зуухыг бүрэн засварт оруулсанаар эх үүсвэрт ямар нэг гэмтэл саатал гарахгүй хэвийн горимоор ажиллах нөхцөл бүрдэж байна.

Баруун-Урт сумын дулааны станцын үнс зайлуулах системийг ашиглалтад орууллаа. Дулааны станц ашиглалтад орсон 2013 оноос хойш станцаас ялгарах үнсийг задгай талбайгаас гар аргаар ачиж, зөөвөрлөдөг байсан юм. Баруун-Урт сумын дулааны станцыг 2013 онд КОИСА олон улсын байгууллагын 7.0 сая долларын санхүүжилтээр барьж гүйцэтгэсэн ба эдэлгээний явцад зарим тоног төхөөрөмж элэгдэлд орсонтой холбоотойгоор санхүүжүүлэгч байгууллагаас дахин судалгаа хийн, төслийн дараах дэмжлэг хөтөлбөрийн хүрээнд уг ажлыг гүйцэтгэж, усны хоолойг хөлдөхөөс хамгаалах хамгаалалт, галын аюулгүй ажиллагааны зарим тоног төхөөрөмжийг нэмэлтээр олгосон байна.

Мал аж ахуйн чиглэлээр: Монгол улсын Засгийн газрын 2019 оны 285 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2019 оны "Аймаг, сумдын аюулгүйн нөөцөд өвс бэлтгүүлэх тухай" А/442 дугаар захирамжийн дагуу аймгийн аюулгүйн нөөцөд 9000 боодол өвс худалдан авахаар аж ахуй нэгж, иргэнтэй гэрээ хийсэн. Одоогоор аймгийн аюулгүйн нөөцийн өвсний хашаанд 6140 боодол өвс нуруулдан хураан авсан.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 285 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2019 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн өргөтгөсөн хуралдаанаар "Аймаг, сумдын хэмжээнд мал мах бэлтгэх, нийлүүлэх ажлыг эрчимжүүлэх" чиглэлээр өгөгдсөн үүрэг, аймгийн Засаг даргын А/580 дугаар захирамжийн дагуу махны нөөц бүрдүүлэх, борлуулах ажлыг шат дараатай зохион байгуулж байна. Тухайлбал: Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж буй өргөтгөсөн үзэсгэлэн худалдаанд Түмэнцогт, Асгат, Мөнххаан, Уулбаян, Баруун-Урт сумдын нийт 296 гулууз махыг 1 кг тутмыг нь 5500 төгрөгөөр худалдан борлуулж байгаа бөгөөд иргэдийн сэтгэл ханамж болон борлуулалт сайн гэсэн мэдээллийг Мал эмнэлгийн газраас ирүүлээд байна.

2019-2020 онд аймгийн хэмжээгээр 13 сумын 67 багийн 4522 хот айлын 7986 малчин өрхийн 4276.4 мянган толгой мал өвөлжиж, хаваржих урьдчилсан дүн гараад байна. Үүнээс сум орон нутагтаа 6398 малчин өрхийн 3347.0 мянган толгой мал, өөрийн аймгийн өөр сумын нутагт 1094 өрхийн 579.2 мянган толгой мал, хилийн хориотой зурваст 322 өрхийн 230.7 мянган мал, тусгай хамгаалалттай бүс нутагт 57 өрхийн 40.7 мянган мал, Өөр аймгийн нутаг буюу Дорнод аймгийн Матад, Хэнтий аймгийн Баянхутаг, Баян-Овоо, Галшар сумдын нутагт 115 өрхийн 78.8 мянган мал тус тус өвөлжинө.

Өвөлжилтийн бэлтгэл хангах хүрээнд аймгийн аюулгүйн нөөцөд 480 тн өвс, 20 тн тэжээл, сумдын аюулаас хамгаалах нөөцөд 1050 тн өвс, 155 тн тэжээлийг сум бүр нөөцийнхөө агуулах,

хашаанд нөөц бүрдүүлээд байна. Малчид, иргэд 11760.7 тн өвс, 525.0 тн ногоон тэжээл, 2030 тн үйлдвэрийн тэжээл, 453 тн гар тэжээл, 15495 тн давс, хужир шүү бэлтгэсэн.

Аймгийн хэмжээгээр мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэлийг 81.3 хувьтай хангаад байна.

ХХААХҮЯ, Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв, Тогтвортой хөдөө аж ахуй төсөлтэй хамтран “Хүнсний ногооны аж ахуйн эрхлэх зохистой дадал” Зүүн бүсийн тариаланчид, мэргэжилтнүүдийн хамруулсан сургалтыг 10 сарын 28-29-ний өдрүүдэд зохион байгууллаа. Тус сургалтанд Хэнтий, Дорнод аймаг, аймгийн 13 сумын нийт 150 гаруй тариаланчид хамрагдлаа.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/503 дугаар захирамжаар Аймгийн хэмжээнд: адуу 3270, тэмээ 400, үхэр 2520, хонь 18910 ямаа 12070, нийт 37170 толгой малд генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэх ажлыг Эрдэнэцагаан сумын Үзэмчин хонь ХХК, Мөнххаан сумын Баясгалант Сүрэг ХХК, Түмэнцогт сумын Түмэнцогт ОНӨҮГ хариуцан гүйцэтгэж байна.

Аймгийн Засаг даргын А/260 дугаар захирамжаар үржилд ашиглаж байгаа бог малын бүх хээлтүүлэгчийг 100 хувь үзлэг ангилалт хамруулахаас Түвшинширээ, Уулбаян, Түмэнцогт, Асгат, Мөнххаан, Эрдэнэцагаан, Баяндэлгэр, Баруун-Урт, Халзан, Сүхбаатар, Наран, Онгон сумдын 11100 толгой хээлтүүлэгчийг хамруулаад байна.

Мал эмнэлгийн чиглэлээр: Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцины дархлааны хөдлөл зүйг тодорхойлох, вакцины нийт сүргийн вакцинд хамрагдалтын хувийг тогтоох зорилгоор нийт 3 сумын 45 малчин өрхийн 675 дээжийг цуглуулаад байна.

Хүнс худалдаа үйлчилгээ, жижиг дунд үйлдвэрлэлийн талаар: Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын санаачилгаар аймгийн Засаг даргын Тамгын газар, Ажил олгогч эздийн холбооны Сүхбаатар аймаг дахь салбар хороо хамтран “Ажил олгогч бизнес эрхлэгчдийн бүсчилсэн зөвлөгөөн”-ийг Онгон суманд зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээний хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгогдсон зээл, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгогдсон урт хугацаатай хөнгөлөлттэй зээлд хамрагдсан иргэн, аж ахуй нэгжийн нийтэд сурталчлан таниулж, сангаас хөнгөлөлттэй зээлд хамрагдсан үйлдвэр эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор үзэсгэлэн худалдаа зохион байгуулж ажиллалаа. Тус арга хэмжээнд Наран, Онгон, Халзан, Баяндэлгэр, сумын нийт 70 гаруй ажил олгогч, бизнес эрхлэгчид оролцсон байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас Хүнс, хөдөө аж ахуйн газар, Стандарт хэмжил зүйн хэлтэс, Эрүүл мэндийн газар, Монголын тогоочдын холбооны Сүхбаатар аймаг дахь салбар холбоо, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын Сүхбаатар аймаг дахь салбар танхим зэрэг байгуулагуудтай хамтран “Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” аяны арга хэмжээг Мөнххаан суманд зохион байгууллаа. Арга хэмжээнд Мөнххаан, Халзан, Баяндэлгэр, Уулбаян, Түмэнцогт сумдын хоол үйлдвэрлэл, худалдааны салбарын нийт 110 гаруй төлөөлөл оролцож хоол үйлдвэрлэл, худалдааны салбарт төрөөс хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээний талаар мэдээлэл авсан ба энэ үеэр сумдын бүсийн аварга тогооч, худалдагч шалгаруулах тэмцээнийг зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд багийн дүнгээр Мөнххаан сум тэргүүн байр эзэллээ.

Монголын залуучуудын холбооны Сүхбаатар аймаг дахь салбар холбоо, Монгол банкны Сүхбаатар аймаг дахь салбараас санаачлан Засаг даргын Тамгын газар хамтран аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид, бизнес эрхлэгчдэд зориулан “Бидэнд боломж байна” Бизнес- Санхүүжилтийн орчин сэдэвт сургалт хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Тус сургалтанд Сүхбаатар аймагт үйл ажиллагаа явуулж байгаа бүх арилжааны банкны салбарууд мөн Зээлийн батлан даалтын сан урилгаар оролцож бизнесийн зээлийн мэдээллийг хүргэж хэлэлцүүлэг өрнүүллээ. Энэхүү үйл ажиллагаанд Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсээс Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангаас олгогдсон урт хугацаатай хөнгөлөлттэй зээлд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийг сурталчилж, орон нутаг ямар бодлого шийдвэрийн түвшинд хөнгөлөлттэй зээл олголтыг зохион байгуулсан, сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа ямар түвшинд яваа эсэх, Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээний

тухай хуулийн шинэчлэлийн талаар мэдээлэл хүргэж ажиллалаа. Уг сургалтанд нийт 80 хүн хамрагдсан байна.

Газар тариалан: 2019 онд аймгийн хэмжээнд Улаанбуудай 2250 га, Овьёос 600, Арвай 101, Техникийн ургамал 970 га, малын тэжээл 700 га, нийт 4717,9 га талбайд Түмэнцогт, Эрдэнэцагаан сумын 3 аж ахуй нэгж тариалсан. Мөн 13 сумын 30 аж ахуйн нэгж, 203 иргэн төмс 65,2 га, Хүнсний ногоо 31,7 га-д тариалсан. Өмнөх оныхоос төмс 6,5 га-аар, Хүнсний ногоо 2,1 га-аар тус тус нэмэгдсэн ба төмс 573 тн, хүнсний ногоо 260,1 тн хураан авсан.

Байгаль орчин, аялал жуулчлал, газар зохион байгуулалтын чиглэлээр:

Хог хаягдал, орчны бохирдлын талаар: Хоггүй цэвэрхэн монгол аяны хүрээнд 10 сард “Хогийн саваа шинэчлэе” арга хэмжээг зохион байгуулж Аймгийн төвийн 2 сургууль, сумдын 12 сургуульд хог хаягдалаа ангилан ялгах буланг тохижуулах ажлыг зохион байгуулж нийт 28 ширхэг самбар, 56 ширхэг ангилан ялгадаг хогийн савыг сумдад өгч ажиллалаа.

Сургалт сурталчилгааны талаар: Хууль бус ан, Зэвсэг -2019 нэгдсэн арга хэмжээний хүрээнд БОАЖГ, Цагдаагийн газартай хамтран хяналт шалгалтыг Мөнхаан, Түмэнцогт сумын зарим нутгаар хийж нийт 7 айл өрхөөр явж хууль бус ан агнуураас урьдчилан сэргийлэх талаар хууль эрх зүйн орчныг тайлбарлах таниулах зэрэг арга хэмжээг авсан ба 1 зөрчил илрүүлж 2.0 сая төгрөгийн нөхөн төлбөр тавьсан байна.

Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд түймрийн эрсдэл бүхий 6 сумын Засаг даргатай хамтран ажиллаж байгаа бөгөөд түймэр гарах эрсдэл бүхий сумын байгаль хамгаалагч нар малчин өрхүүдээр багийн засаг даргын хамт явж ажиллан сурталчилгаа хийсний зэрэгцээ хээрийн түймэр гаргахгүй гэсэн гарын үсгийн баталгаа гаргуулан, давхардсан тоогоор 10 орчим мянган иргэнд танилцуулга урьдчилан сэргийлэх ажлыг хүргээд байна.

Амьтны аймаг, гамшгийн чиглэлээр: БОАЖЯамны санхүүжилтээр 1:200,000 масштабтай гидрогеологийн судалгааны ажлын хүрээнд тус аймгийн нутагт 6 ширхэг Зэрлэг ан амьтадад зориулсан гүн өрмийн худаг гаргах ажлыг Эрдэнэ Дрилийг ХХК, Дунар-Од ХХК нар хийж гүйцэтгэлээ. Үүнд Эрдэнэцагаан сумын нутаг Уртын цагаан орчимд 1, Лхачинвандад уулын ар дор бугын аман усанд 1, Эрдэнэцагаан сумын 3,2-р засвавын хооронд 1, Дарьганга сумын урд Онгоны 7-р заставын урд 1, Наран сумын Баавхайн говьд 1, Онгон сумын 5 уулын хойно 1 тус тус гарган, сумын ЗДТГазарт хүлээлгэн өгөөд байна.

Мөн Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газрын санжүүжилтээр Баруун-Уртаас- Мөнххаан, Мөнххаанаас Давсан бадрах, Давсан бадрахаас Түмэнцогт, Түмэнцогтоос Хөлөнбуйр гэсэн чиглэлийн хатуу хучилттай зам дагуу Зэрлэг ан амьтан хамгаалах зорилгоор 30 ширхэг анхааруулах тэмдэг байршуулах ажлыг 514 км зам дагуу босгож тогтоох ажлыг аймгийн БОАЖГ-аас хийж гүйцэтгээд байна.

Ногоон байгууламж: Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 2018 онд хэрэгжүүлж эхэлсэн “Хандлагаа өөрчилъе” багц ажлын хүрээнд Баруун-Урт сумын 1-р багт “Ногоон паспорт-Ногоон төгөл” модлог ургамлын цэцэрлэг байгуулах ажлын нээлт боллоо. Нээлтийн үеэр төвийн Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын 4 сургуулийн 400 сурагч, багш нарын хамт оролцож 11 төрлийн 500 ширхэг мод тарилаа. Энэхүү бичил цэцэрлэг байгуулах газарт 7-8 метрийн өндөр овоолго шороотой, хотгор гүдгэртэй, хогтой амаргүй газар байсан газрыг тэгшлэх ажилд Цайрт-Минериал ХХК, Сүхбаатар-Тохижилт ОНӨҮГ ажиллаж, 900 м газарт хашаа барих, 500 модны нүх ухах ажлыг Зэвсэгт Хүчний 338-р анги хамтран ажилласан байна.

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63, 2013 оны 178 дугаар зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Асгат, Түвшинширээ сумын цэцэрлэгт хүрээлэнд 1600ш мод нөхөн тарилтаар тарьсан байна.

Уул уурхайн чиглэлээр: Аймгийн Засаг даргын 2019 оны А/62 дугаар захирамжаар зохион байгуулагдсан “Байгаль орчинд ээлтэй хариуцлагатай уул уурхай ба орон нутгийн хамтын ажиллагаа 2019” уул уурхайн зөвлөгөөнөөс гарсан зөвлөмж, орон нутагт холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн авто замын засвар арчлалт гүйцэтгэх, авто замын засварт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах зөвшөөрөл олгох, тээвэрлэлтийн чиглэл батлах тухай зөвлөлдөх

уулзалтыг 10 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулж “Андын Илч”, “Бадмаараг хаш”, “Олгой булаг”, “Нагааранз”, “Премиум көүл” ХХК-уудад бүтээгдэхүүн тээвэрлэлтийн авто замын засвар арчлалтыг гүйцэтгэх зөвшөөрлийг олгох, тээвэрлэлтийн чиглэлийг түр батлах шийдвэр гарсан байна.

Аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн удирдамжаар томилогдсон ажлын хэсэг Сүхбаатар сумын нутагт ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Цайрт минерал” ХХК-ийн уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн авто замын засвар арчлалт хийсэн байдал, тээвэрлэлтийн чиглэл, маршрутын зөрчиж байгаа эсэхийг газар дээр нь үзэж шалгаж, гарсан зөрчил дутагдлыг арилгуулах талаар холбогдох үүрэг чиглэл өглөө.

Түүнчлэн 2019 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх ажлын хэсэг “Цайрт минерал” ХХК-д ажиллаж байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, тайланг хүлээн авсан.

Зам тээврийн салбарт: Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж буй аймгийн төвийн 4-р тойргийн 9,1 км хатуу хучилттай авто замын байгууламжийн ажлын гүйцэтгэл, орон нутгийн төсвийн хөрөнгөөр Баруун-Урт сумын 2, 3-р багт гэр хорооллын дундах 1,2 км хатуу хучилттай авто замын ажилд орон нутгийн зүгээс хяналт тавьж ажиллаж байна. Мөн аймгийн төвийн хатуу хучилттай авто замын хэсэгчилсэн засвар, шинэчлэлтийн ажлыг орон нутгийн авто замын сангийн хөрөнгөөр “Талын зам” ТӨХК-аар гүйцэтгүүлж, хяналт тавин ажиллаж байна.

Баруун-Урт сумын 3,4-р сургууль орчимд “Сургууль орчмын аюулгүйн бүс” байгуулах ажлын гүйцэтгэгчээр “Том ноёд” ХХК шалгаран гэрээ байгуулаад байна.

Тав. Бусад салбарт хийгдсэн ажил

Онцгой байдлын газар: Төрийн хяналт шалгалтын тухай, Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хууль, гал түймрийн улсын хяналтын дүрэм, Барилга байгууламжийн галын аюулгүй байдал / БНБД 21-01-02/, Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм/ БНБД 21-02-02/, Барилга байгууламжийн гал унтраах автомат тоног төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл /БНБД 21-04-05/, Цахилгаан байгууламжийн дүрэм БД 43-101-03, Цахилгаан техникийн ажил БНБД 3.05.06.90, Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер БНБД 41-01-02, Барилгын доторх усан хангамж БНБД 40-05-98, Аж ахуй нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм MNS 5566:2005 зэрэг стандарт, галын аюулгүйн норм техникийн норматив дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулах хүрээнд аймгийн Засаг Даргын “Аюулгүй байдлыг хангуулах тухай” А/585 дугаар захирамж болон баар, караоке, цэнгээний газруудад гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх хяналт шалгалтын удирдамжийн дагуу хяналт шалгалтын ажлыг зохион байгуулаа. Хяналт шалгалтыг нийт 40 албан байгууллага, аж ахуй нэгжид зохион байгуулж, нийт 281 зөрчил илрүүлэн шалгалтын хугацаанд 26 заавал биелүүлэх албан шаардлага, 1 мэдэгдэл бичиж хүргүүлэн биелэлтийг хангуулан ажиллаж байна. Холбогдох хууль тогтоомж зөрчсөн 1 иргэнийг 100000 төгрөг, 1 хуулийн этгээдийг 1000000 төгрөгний захиргааны шийтгэл ноогдуулж, 5 аж ахуйн нэгж, байгууллагуудад ажлын байрны дүгнэлт гаргаж 62500 төгрөг, нийт 1162500 төгрөгийг аймгийн Татварын хэлтсийн дансанд төвлөрүүлэн ажилласан.

Мөн гал түймрийн холбогдолтой 3 удаагийн гомдол мэдээллийг хүлээн авч Прокурорын байгууллагаас зөрчлийн хэргийн дугаар авч шийдвэрлэсэн, хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн, татгалзах саналтай материал тус тус үйлдэж аймгийн Прокурорын газрын хяналтанд хүргүүлсэн. гал түймэр гарсан тухай акт-2, шинжээчийн дүгнэлт, 1 үйлдэж холбогдох газруудад хүргүүлсэн.

Засгийн Газрын 2018 оны 317 дугаар тогтоолын дагуу Баруун-Урт сумын 01 дүгээр багийн нутагт орших Дашваанжил ХХК-ны хийгээр цэнэглэх станцын барилга, Ногооны зоорийн барилга хүлээн авах улсын комиссд ажиллан үүрэг чиглэлийг өгч биелэлтийг хангуулан ажиллаж байна.

“Гамшгийн эрсдэлийг бууруулах Олон улсын өдөр” буюу 10 дугаар сарын 11-ний өдөр “Төгс бүтээцгээе” уриан дор Сүхбаатарын талбайд гамшгаас хамгаалах албадыг оролцуулан, ард иргэдэд ухуулга сурталчилгааг зохион байгуулан байгууллагын үйл ажиллагаа, онцлогийг

харуулан олон нийтэд хууль тогтоомжийг сурталчлан ажилласан ба “Хэн ч, Хэзээ ч, Хаана ч Бэлэн” буухиа тэмцээнийг Уулбаян суманд явуулсан.

Мөн тус өдөрлөгийн хүрээнд иргэдийг болзошгүй гамшиг, ослын аюулаас урьдчилан сэргийлэх, мэдлэг чадварыг дээшлүүлэх, эрсдэл эмзэг байдлыг бууруулах зорилгоор Гал түймэр унтраах, аврах 15 дугаар ангийн албан хаагчид өөрсдийн хариуцсан Баруун-урт сумын 1-7 дугаар багийн нийт 850 айл өрхөөр орж үзлэг шалгалт хийн заавар, зөвлөмж өгч санамж, материал тараан ухуулга сурталчилгааны ажлыг зохион байгууллаа. Нийт 2550 иргэнд санамж, гарын авлага тараан, 45 зөрчлийг газар дээр нь арилгуулж ажилласан байна.

Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдрийг угтан гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, орон нутгийн сайн дурын идэвхтэн бэлтгэх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Баруун-Урт сумын сайн дурын гишүүдэд Каритас Монгол төрийн бус байгууллагатай хамтран гамшгаас хамгаалах анхан шатны сургалтыг зохион байгууллаа.

Баруун-урт сумын 1 дүгээр сургууль, 3 дугаар сургуулиуд болон Мөнххаан, Түмэнцогт, Уулбаян сумдад гамшгийн эрсдэлийн тойм судалгаа хийгдээд байна.

Зүүн бүсийн аварга шалгаруулах “Өсвөрийн аврагч-2019” тэмцээнийг 10 дугаар сарын 03-ны өдөр Баруун-Урт суманд Дорнод, Хэнтий аймгийн сургуулиудын дунд зохион байгуулж, өсвөрийн аврагч бүлгийн 24 сурагч хурд хүч авхаалж самбаагаа сорин оролцоноос Баруун-Урт сумын 1-р бүрэн дунд сургуулийн “Шонхор” бүлэг түрүүлж Улаанбаатар хотноо зохион байгуулагдах улсын аварга шалгаруулах “Өсвөрийн аврагч-2019” тэмцээнд оролцох эрхийг авсан ба улмаар “Өсвөрийн аврагч-2019” улсын аварга шалгаруулах анхдугаар уралдааны "ДЭД БАЙР"-ыг эзэллээ.

Мэргэжлийн хяналтын газар: Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 1 аж ахуйн нэгжид төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, 18 зөрчлийг илрүүлж, 2000.0 мянган төгрөгийн торгууль оногдуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгсөн.

Хууль бус ан агнуураас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 01/26 тоот удирдамжийн дагуу хяналт шалгалт хийж, гурван толгой цааган зээр зөвшөөрөлгүй агнасан зөрчилд Зөрчлийн тухай хуулийн дагуу 150 нэгжээр торгох шийтгэл оногдуулж, 3000.0 мянган төгрөгийн нөхөн төлбөр оногдуулсан.

Бичигт боомтоор 10 сарын байдлаар 3664 зорчигч, 1908 тээврийн хэрэгсэл нэвтэрсэн бөгөөд үүнээс импортын хяналт шалгалтад 1853 зорчигч, 998 тээврийн хэрэгсэл, экспортын хяналт шалгалтад 1811 зорчигч, 910 тээврийн хэрэгсэл хамрагдсан.

Экспортын хяналт шалгалтад 1 аж ахуйн нэгжийн 14626.56 тн түүхий нефть, 2 аж ахуйн нэгжийн 1995.91 тн хүрэн нүүрс, 2 аж ахуйн нэгжийн 657.21 тн жонш, 1 аж ахуйн нэгжийн 3903.9 тн төмрийн хүдрийн баяжмал хамрагдсан байна. Импортын хяналт шалгалтад 4 аж ахуйн нэгжийн 4,3 тн төмс, хүнсний ногоо, 1,9 тн нарийн ногоо, 0,4 тн жимс, жимсгэнэ хамрагдсан байна.

Хяналт шалгалтын явцад экспортлогч улсын гарал үүслийн гэрчилгээгүй, чанарын шаардлага хангаагүй “Будаг шингэлэгч” 10 л, “Дотно сэтгэл” бэлэн гоймон 15,2 кг-ийг импортолсон 2 иргэний зөрчлийг илрүүлж, дээрхи бүтээгдэхүүнийг бодис, бараа, бүтээгдэхүүнийг буцаах 2 мэдэгдэл үйлдэн экспортлогч улсад нь буцаах арга хэмжээ авав.

Хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд “Мэргэжлийн хяналтын байгууллага иргэн таныг сонсож байна” арга хэмжээг зохион байгуулж, хяналтын чиглэл бүрээр гарын авлага материал, зөвлөмж сэрэмжлүүлгийг иргэдэд хүргэж, иргэдийн саналыг санал асуулгын хуудсаар авч тулгамдаж буй асуудлыг газар дээр нь шийдвэрлэж ажиллалаа.

Аймгийн засаг даргын А/589 дүгээр захирамжаар аймгийн хэмжээнд архи согтууруулах ундаа худалдах болон түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжүүдэд аттестатчиллын хяналт шалгалтыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байна.

Соён гэгээрүүлэх чиглэлээр хийгдсэн ажлууд: 3 ААН, 120 зорчигчдод 2 төрлийн зөвлөмж, сэрэмжлүүлгийг бэлтгэн inspection.gov.mn, shilenhyanal.gov.mn сайтуудыг сурталчилж, соён гэгээрүүлэх ажлыг хийж хэрэгжүүллээ.

Зургаа. Сумдад зохион байгуулагдсан ажил**Баруун-Урт:**

Төрийн удирдлагын чиглэлээр: Сүхбаатар аймгийн цэргийн штаб, Баруун-Урт сумын ЗДТГазар хамтран 2019 оны 2-р ээлжийн цэрэг татлагыг 2019 оны 10-р сарын 15-17 өдрүүдэд зохион байгуулж, 18-26 насны иргэдийн цэргийн нэгдсэн үзлэгт оруулж Цэргийн штабаас ирүүлсэн ханалтын тоог хангаж ажилласан.

Аймгийн цагдаагийн газар, БОАЖГ-тай хамтран “Хууль бус ан-Зэвсэг 2019” нэгдсэн хяналт шалгалтын удирдамжийг батлуулан 10-р сарын 20-ны өдрөөс 45 хоногийн хугацаатай хяналт шалгалтыг хамтран хийж гүйцэтгэсэн. Шалгалтаар иргэдэд Зөрчлийн тухай хуулийг сурталчилан, хууль бус ан агнуур хийхгүй байх талаар зөвлөгөө өгсөнөөс гадна зөрчил гаргасан иргэнд хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцон ажиллалаа.

Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэгт сумын 600 малчин өрхөд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр заавар зөвлөмж өгч, 300 малчин өрхийн байршлыг grs-р тогтоолгосон.

Тус сумын 3-р багийн нутаг дэвсгэрт объектийн гал гарсаны улмаас 20 иргэн 15-90% түлэгдэлтэй, 1 иргэн нас барсан харамсалтай хэрэг гарсан ба ЗДТГ-ын холбогдох албан тушаалтнууд газар дээр нь ажиллаж галд өртсөн иргэдэд сэтгэл санааны болон эд хөрөнгийн тусламж дэмжлэг үзүүлсэн. Сумын ЗДТГ-аас 1,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

9-р багийн ажлын албанаас Хээрийн нөхцөлд багийн иргэдийн нөхөрлөлийг бэхжүүлж, иргэд бие биетэйгээ танилцах, нөхөрлөх, чөлөөтэй орчныг бий болгох зорилгоор хээрийн цай арга хэмжээг зохион байгуулсан. Нийт 47 иргэнийг хамруулсан бөгөөд 20-35 насны 19 иргэн, 45-65 насны 21 иргэн, 0-15 насны 7 иргэн хамрагдсан. Энэхүү үйл ажиллагааг Сумын ИХТ нар, багийн ажлын алба, багийн ИНХ-ын тэргүүлэгч нар хамтран зохион байгуулсан.

Боловсролын чиглэлээр: Аймгийн Боловсрол соёл урлагийн газартай хамтран Монгол багш нарын 53 дах өдрийг угтан уламжлалт Волейболын тэмцээн зохион байгууллаа. Тэмцээнд Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш ажилтнуудаас бүрдсэн эрэгтэй 7 баг, эмэгтэй 13 багийн нийт 150 гаруй тамирчид оролцон 2019 оны 09 дүгээр сарын 27,28-ны өдрүүдэд зохион байгуулагдаж хурд хүч авхаалж самбаагаа уралдуулан өрсөлдлөө.

Эрүүл мэндийн чиглэлээр: 9-р багийн ажлын албанаас Энэрэл ӨЭМТ-тэй хамтран “Эрүүл иргэн” эрүүл мэндийн өдөрлөг зохион байгуулж, 43 иргэнийг хамруулсан.

Хот тохижилтын хүрээнд: Аюултай хог хаягдлын чиглэлээр ЭМГ-тай уулзалт зохион байгуулж цаашид хэрэгжүүлэх ажил арга хэмжээ, хувийн хэвшлийн эмнэлэгүүдийг аюултай хогийг зөөж тээвэрлэх чиглэлээр шийдвэр гаргасан. Хогийг Сүхбаатар Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-тай шууд гэрээ байгуулан зөөвөрлөж байна.

БОАЖЯамнаас ногоон паспорт аяны хүрээнд төв суурин газарт ногоон төгөл байгуулах ажлыг 1-р багийн нутаг дэвсгэрт амгалан хошуу гэх газарт 3 га талбайд 500 ш модыг Ерөнхий сургуулиудын эко бүлгийн 250 хүүхэд болон Шаргын модод ХХК хамтран тарьлаа.

Сүхбаатар ойжуулалт сум дундын ойн анги нь Улаанбаатар хотын зам дагуу 1700 ш мод, Уртын голын эргийн дагуу 1300 ш модыг тус тус тарьсан.

7-р багийн нийтийн эзэмшлийн орон сууцны дундах талбайг тохижуулах ажлыг Молцог элс ххк 156,0 сая төгрөгөөр, тус багийн нарлаг хотхоны дундах талбайг тохижуулах ажлыг Шарга ххк 70,0 сая. төгрөгийн өртөгтэй тус тус хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.

Баяндэлгэр:

Төрийн удирдлагын ажлын чиглэлээр: Сумын засаг даргын 2019 оны А/113 дугаар захирамжаар “Соёлын биет болон биет бус өв”-ийн үзэсгэлэнг 6 багийн дунд зохион байгуулаа.

Сүхбаатар аймгийн төв /Баруун-Урт сум/-д объектын гал гарч хүний амь нас эрсдсэн, олон хүн түлэгдэж хохирсонтой холбогдуулан сумын Засаг даргын “Аюулгүй байдлыг хангуулах тухай” 2019 оны А/125 дугаар захирамж гарч тус суманд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж

байгууллагуудад Цагдаагийн тасагтай хамтран хяналт шалгалт хийж анхааруулга зааварчилгааг өгч ажиллалаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Нээлтэй хаалга”-ны өдөр зохион байгуулж байх тухай” 2007 оны 97-р зарлиг, төрийн байгууллагын үйл ажиллагааг иргэдэд сурталчлах, төрийн үйлчилгээг нэг цэгээс хүргэх зорилгоор 10 дугаар сарын 14 –нд “Нээлтэй хаалга”-ны өдрийг зохион байгуулж, 13 албан хаагчид 18 төрлийн төрийн үйлчилгээг 85 иргэнд хүргэж, давхардсан тоогоор 167 иргэнд гарын авлага материал тараасан байна.

Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

ЕБСургууль: Дэлхийн гар угаах өдрөөр охидын клубынхан өртөөчилсөн сургалт зохион байгууллаа.

Эрүүл мэндийн төв: “Эх хүүхдэд ээлтэй эмнэлэг орон нутаг” аяны хүрээнд Хонгор багийн эмч баг тойролт хийж 0-2 насны 12 хүүхэд, өндөр настан болон хэвтрийн өвчтэй 16 иргэн, жирэмсэн 3 эмэгтэйд урьдчилан сэргийлэх үзлэг хийж, 40-64 насны 62 хүнийг артерийн даралт чихрийн шижингийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан байна.

БЗДХ-ын урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд 46 иргэнийг хамруулсан.

Соёл: Аймгийн Угсаатны зүйн музейн 70 жилийн ойд зориулсан “Дарьгангын мөнгөн урлал” явуулын үзэсгэлэн дэлгэгдэж 200 хүн үзэж сонирхлоо.

Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн хүрээнд:

Байгаль орчин: БОАЖСайдын 2012 оны А/299 дүгээр журамын дагуу Орон нутгаас идлэг шонхор барих отогуудтай 8 шонхорын гэрээ актыг байгуулан 51.200.000 төгрөгийг холбогдох дансанд төвлөрүүллээ.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: Сумын аюулгүйн нөөцөд 2025 боодол өвс нөөцөлсөн дүн мэдээтэй байна.

Дарьганга:

Төрийн удирдлагын чиглэлээр: Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор шагналын сан 1,8 сая төгрөгийн шагналын сантай “УРЛАГИЙН НААДАМ” зохион байгуулах удирдамжийг хэлэлцэн баталлаа. Уг наадамд хөдөөгийн 4 баг, 5 төсвийн байгууллага, нийт 9 баг оролцох юм.

Засгийн газрын 2017 оны 01 дүгээр албан даалгавар, 2018 оны 258 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2018 оны А/207 дугаар захирамжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу сумын ИТХ, ЗДТГ, Цагдаагийн хэсэг хамтран төсвийн 5 байгууллагад гэнэтийн шалгалтыг ажлын цаг ашиглалт, ажлын байрны эмх цэгцийн асуудлаар хийхэд ноцтой зөрчил илрээгүй ч ажлын цагаар согтууруулах ундаа хэрэглэсэн 3 багшийн асуудалд сумын Засаг даргын албан бичгийг хүргүүлсэнээр, ЕБС-ийн захирлын дэргэдэх зөвлөл хуралдаж уг асуудлыг хэлэлцэн арга хэмжээ аваад байна. Мөн байгууллагуудад Төрийн албаны тухай хуулийн шинэтгэлийн хүрээнд гарсан тогтоол шийдвэрийн жагсаалт, Боловсрол соёлын ажилтны ёс зүй, Эрүүл мэндийн ажилтны ёс зүй, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүй” –гээр хийсэн гарын авлага зэргийг тархаалаа.

Хөрөнгө оруулалт, хөдөө аж ахуй, дэд бүтэц, байгаль орчны чиглэлээр: Сумын хэмжээнд 1030 га талбайд огтоно тархсан судалгааг гаргаад байна.

Хөдөө аж ахуйн бэлтгэл ажлыг хангах хүрээнд хадлангийн бүлэг 975 тн өвс, иргэд 350 тн өвс татсан бол сумын өвсний фондод аюулгүйн нөөцөд 105 тн өвсийг нөөцлөөд байна.

Сургалт, сурталчилгааны ажлын чиглэлээр: Сумын Засаг даргын 2019.09.09 ний өдрийн А/90 дүгээр захирамжаар “НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨР”-ийг сумын ИТХ, ЗДТГ-аас хамтран зохион байгуулахаар шийдвэрлэж, удирдамж төлөвлөгөөг батлуулан 09 сарын 15-23-ныг хүртэлх хугацаанд 4 багт зохион байгууллаа. Үүнээс 4 багт 722 хүн, сумын төвд зохион байгуулсан өдөрлөгт 221 хүн, нийт 943 хүн хамрагдлаа. 221 хүний 41,6 хувь буюу 92 хүнээс 3 асуумж бүхий саналын хуудсаар санал асуулга авлаа.

- Нээлттэй хаалганы өдрөөр аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга, бусад төлөөлөл оролцсон баг суманд ажиллаж, “Даатгуулагч танд зөвлөө, тусалъя” аяны хүрээнд сургалт мэдээлэл, сурталчилгаа хийсэн.

- Аймгийн ГБХЗХГ-ын баг хамт олон суманд 2019.09.12 нд ажиллаж “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга”, “Бэлгийн замаар дамжих халдварт өвчин” сэдвийн хүрээнд сургалт хийж 50 гаруй хүн хамрагдлаа.

- Монгол улсын Үндэсний зөвлөх багш Цэгмэджав багшийг урьж ирүүлэн 3 хоног ажиллуулж 4 чиглэлийн сургалтыг 09 сарын 14,15-ны өдрүүдэд иргэд, төрийн албан хаагчид, суралцагчид, багш нарт зохион байгууллаа. Нийт 170 хүн хамрагдав.

-ЗДТГ-ын гэр бүлийн зөвлөгч болон халамжийн мэргэжилтэн нар хариуцан нийгмийн халамжийн үйлчилгээ, Нийгмийн даатгалын чиглэлээр болон “Хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэх нь”, “Бэлгийн замаар дамжих халдварт өвчин” зэрэг сэдвээр зорилтот бүлгийн өрхүүдийн төлөөлөл болох 16 хүнд сургалт зохион байгууллаа.

-Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд 9-р сард 300 тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалтыг хийж, 20 жолоочид хуулийн дагуу 400000 төгрөгийн, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 6 жолоочид 2,400,000 төгрөгийн, жолоодох эрхийн үнэмлэхгүй 4 жолоочид 800000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, хадлан тэжээл бэлтгэж буй иргэдэд замын хөдөлгөөний аюулгүй байдал, Зөрчлийн тухай хуулиар сургалт мэдээлэл хийж нийт 120 хүнийг хамрууллаа.

Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын чиглэлээр:

Эрүүл мэнд: Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын техникийн дэмжлэгтэй Солонгосын иргэдийн сангийн санхүүжилтээр “Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ болон олон нийтийн түвшинд эрүүл мэндийн мобайл технологийг нэвтрүүлэх нь” төслийн хүрээнд аймгийн нарийн мэргэжлийн эмч нартай хамтран үзлэг, шинжилгээг сумын бүх багт зохион байгуулахад дотор 256, ЭХО- 340, мэдрэл 95, чих хамар хоолой 45, шүдний үзлэгт 68 иргэн хамрагдлаа. Мөн 15 насны 35 сурагчаас БЗХӨ-ний шинжилгээ авлаа.

“Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” улсын аяны хүрээнд аймгийн ЗДТГ-тай хамтран бүсийн зөвлөгөөнийг тус суманд зохион байгуулахад Баруун-Урт, Дарьганга, Асгат, Эрдэнэцагаан, Сүхбаатар сумдуудын багууд оролцож, зөвлөгөөний үеэр тусгай хөтөлбөрөөр тогооч нарын тэмцээн, биеийн тамир, урлаг уран сайхны тэмцээн уралдааныг зохион байгууллаа.

Боловсрол: Хүүхдийн цэцэрлэг нь гаднах тоглоомыг 4.5 сая төгрөгийн санхүүжилтээр иргэдийн санаачилга дэмжлэгээр, доторх тоглоомыг 5.0 сая төгрөгийн санхүүжилтээр ОНХС-аас шийдвэрлэж суурилуулаад байна.

Гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд 5 настай 9 хүүхдэд сургалтын багц бэлтгэж гардуулсан.

Байгаль орчин: Дэлхийн нүүдлийн шувуудын өдрийг “ШУВУУ ХАМГААЛАЛ, ХУВАНЦАРЫН БОХИРДОЛД ШИЙДЭЛ БИЙ” уриан дор тэмдэглэн өнгөрүүлсэн бөгөөд ЕБС-ийн 6-10 дугаар ангийн 52 сурагчид хуванцар бохирдлын тулгамдаж буй асуудлууд, тэдгээрийн шийдлийн талаар мэдээлэл өгч, анги бүрийн сурагчид дээрх урианы хүрээнд уриалга дэвшүүлж оролцсон.

Мөнххаан:

Төрийн удирдлагын чиглэлээр: “Иргэдээ сонсьё” өдөрлөгийн сумын ИТХ,ЗДТГ хамтран зохион байгуулж баг бүр дээр 1 хоног ажиллаж ЗДТГ-ын мэргэжилтнүүд холбогдох хууль тогтоомжийн талаар мэдээлэл хийсний зэрэгцээ урлаг спортын арга хэмжээг зохион байгуулсан . Энэ арга хэмжээнд нийт 5 багийн 350 орчим иргэд хамрагдсан.

Боловсрол, Соёл, Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

Соёлын төв: Номын сангийн нийт уншлаганд 120 ном гарч 96 хүүхэд, 20 насанд хүрэгчдэд номоор үйлчилсэн.

Сургууль: ЕБС-ийн сурагчид болон 1-5р ангийн эцэг эхчүүдийн дунд “Угийн бичиг” хөтөлх сургалтыг 2 үе шаттайгаар зохион байгуулсан бөгөөд нийт 85 эцэг эх, хүүхдүүд хамрагдсан.

Улаанбаатар хотын “Гэр бүл” шүдний эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээний хүрээнд тус эмнэлгийн эмч нар ирж сургуулийн хүүхдүүдэд үзлэг эмчилгээ хийн, эцэг эхчүүдэд амны хөндийн ариун цэврийн талаар мэдээлэл хийсэн. Нийт 45 хүүхдийн шүдийг эмчилсэн байна.

Хөдөлмөр эрхлэлт: Орон нутгийн онцлог, эрэлт хэрэгцээнд нийцсэн төслийг санхүүжүүлэх хүрээнд Сүү цагаан идээ боловсруулах чиглэлээр ирсэн 1 иргэний төсөл дэмжигдэж 20,0 сая төгрөгийн санхүүжилт олгосон.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр: Суманд Давс багатай бүтээгдхүүн үйлдвэрлэлийг дэмжье аяны хүрээнд баруун бүсийн 7 сумын тогооч, биенес эрхлэгч, худалдагч нарын арга хэмжээ 2 өдөр зохион байгуулагдаж, 18 АА-нэгж, 80 гаруй хүн хамрагдаж шилдэг тогооч, худалдагч шалгаруулах уралдаанд багийн дүнгээр тэргүүлж “Гранпри” шагнал авсан.

Байгаль орчин: БОАЖГ-ын дарга болон сумын засаг даргаар батлуулсан удирдамжийн дагуу БОХУБ болон багийн Засаг дарга нар түймрийн эрсдэл бүхий газруудаар явж ажиллан 4 багийн 105 өрхөөр орж гарын үсгийн баталгааг авсан.

Наран:

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц , Байгаль орчин , Хөдөө аж ахуй чиглэлээр

Сумын 3-р багийн нутагт ОНХсангийн 10.0 сая төгрөгөөр “Нарантунгала” цэцэрлэгт хүрээлэнгийн ажлыг “Баянхишиг ХХК” хийж гүйцэтгэлээ. 60 ширхэг жигд, 20 ширхэг хайлаас мод суулгаж усалгаа хийсэн.

“Хоггүй цэвэрхэн Монгол” багц ажлын хүрээнд сумын ААН, албан байгууллага иргэдийнхээ дунд “Хоггүй сум – Цэвэр орчин” 21 хоногийн аяны хүрээнд нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж 5 албан байгууллагын 50 гаруй албан хаагч, давхардсан тоогоор 80 гаруй иргэдийг хамрууллаа.

Аймгийн засаг даргын 95 дугаар захирамжийн дагуу гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль 10 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд зохион байгуулагдаж мэргэжлийн анги, бүлгүүд, сумын Онцгой комисс, иргэд идэвхтэй хамрагдаж 91.2 А үнэлгээ авсан.

Нийгмийн халамж, Хөдөлмөр эрхлэлт, Боловсрол соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

Олон улсын ахмадын баярыг угтан 09 сарын 23-нд Наран ,Онгон, Дарьганга сумын 180 гаруй ахмадыг хамруулан зөвлөгөөн зохион байгуулсан.

ЕБС, Соёлын төвийн номын сангаас хамтран “Номын баяр-Бидний баяр-2019” чуулгыг албан байгууллагуудын дунд зохион байгууллаа.

Нийгмийн халамж: аймгийн Нэгдсэн эмнэлэг, ХХҮГ-ын холбогдох албан тушаалтнууд ирж асаргааны тэтгэмжийн 37 хувийн хэргүүдийн анхан шатны баримтуудыг нягтлан шалгаж, гэрээр нь очих үзэж шаардлагатай 6 өрхүүдээр асруулагчийн биеийн байдал, асрагчийн гэрээний дагуу үүргээ гүйцэтгэж буй эсэх, өвчтөний онош нь Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 02-р сарын 23-ны өдрийн А/69,48 тоот тушаалын хавсралтаар батлагдсан жагсаалт, шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхэд хяналт шалгалт хийлээ. Хяналт шалгалтаар 4 хүний асаргааг байнгын асаргаа шаардлагагүй иргэн гэж ,1 иргэний өвчний онош байхгүй гэдэг шалтгаанаар асаргааны тэтгэмжийг 11 дүгээр сарын 1-нээс зогсоохоор шийдвэрлэсэн. Улмаар сумын амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдэд арга зүйн зөвлөгөө өгсөн.

Хууль эрх зүй чиглэлээр: 10-р сарын байдлаар иргэдээс сумын Засаг дарга болон Тамгын газрын холбогдох албан тушаалтнуудад хандаж 65 өргөдөл гомдол ирүүлсэнээс 64 өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэж, хугацаа болоогүй 1, шийдвэрлэлт 98.5 хувьтай байна.

Онгон:

Төрийн удирдлагын чиглэлээр: ЗДТГазраас нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгууллаа. Уг арга хэмжээнд давхардсан тоогоор 80 иргэн үйлчлүүлсэн бөгөөд төрийн үйлчилгээ авсан бүх иргэдийг эрүүл мэндийн анхан шатны үзлэгт хамрууллаа.

Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд: Ахмад багш нарын уулзалтыг Улаанбаатар хотод зохион байгууллаа. Уг арга хэмжээнд нийт 103 ахмад багш хамрагдсан.

Хүүхдэд ээлтэй сум аяны хүрээнд ЗДТГазар, ЕБСургууль хамтран Хүүхдийн чуулган зохион байгууллаа.

ЕБСургуульд малчдын хандиваар 8,7 сая төгрөгийн үнэ бүхий иж бүрэн хөгжим техник гэрэлтүүлэг суурилууллаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,3 тэр бум төгрөгийн 160 хүүхдийн бага сургуулийн барилгын ажил хийгдэж байна.

Малчдын хандив тусламжаар урлагын заалны завсарын ажлыг 4,0 сая төгрөгөөр хийлээ.

Хүүхдийн цэцэрлэгт тоглоонгоо суралцъя хөтөлбөрийн 8,0 төгрөгийн санхүүжилт хийгдэж нэг бүр нь 1,0 сая төгрөгийн 8 ширхэг тоглоомтой боллоо.

МУ-ын Ерөнхий сайд сум дундын эмнэлэгт түргэн тусламжийн фургон маркын автомашин гардуулсанаар иргэд түргэн тусламжийн үйлчилгээг шуурхай авах нөхцөл бүрдлээ.

Малчдын хандиваар 8,0 сая төгрөгийн өртөг бүхий Шүдний боор машиныг өсвөр насны шүдний өвчлөлийг бууруулах нь төслийн хүрээнд авч ашиглаж байна.

Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд: Сумын нэгдсэн хогийн цэгийг Кожеговь ХХК-ны хөрөнгө оруулалтаар 40 гаруй сая төгрөгөөр бүтэн сарын хугацаанд тохижуулах ажил 50 хувьтай хийгдэж байна.

Өмнөд бүсийн ЖДҮйлдвэрлэл эрхлэгчдийн чуулга уулзалтыг амжилттай зохион байгууллаа. Уг арга хэмжээнд 100 гаруй иргэн хамрагдлаа.

Сүхбаатар:

Төрийн удирдлагын чиглэлээр: Монголын Үндэсний Олон Нийтийн Радиогийн нэгдүгээр сувгийг хиймэл дагуулаас хүлээн авч сумын төвд гамшиг,онцгой байдлын үеийн зарлан мэдээлэл хүргэх боломжтой боллоо. Уг төхөөрөмжийг Эрүүл мэнд боловсролын сангийн 1,8 сая төгрөгийн санхүүжилтээр Радио телевизийн газраас авч суурилуулаад байна.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 783,4 сая төгрөгийн хөрөнгөөр ЕБСургуулийн спорт заалны барилгын ажлыг Улаанбаатар хотын “Геоканон төв” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд одоогоор суурийн ажил дуусч байна.

ЕБСургуулийн их засварын ажил хийгдэж байна. Ажлын гүйцэтгэл 75 хувь. Сургуулийн их засварын ажлын гүйцэтгэгчээр Дорнод аймгийн “ЦОДММ” ХХК шалгаран гүйцэтгэж байгаа бөгөөд сумын удирдлагууд их засварын явц байдалтай танилцаж, ажил эрчимжүүлэх талаар үүрэг өглөө.

Сумын ЗДТГазар, ИТХ-аас цагдаагийн хэсгийн байрыг засварлах болон гадна хашаа барих ажилд 17,4 сая төгрөгний санхүүжилтийг шийдвэрлэж өгсөний дагуу засвар үйлчилгээг хийж дуусгаад байна.

Сумын төвд цамхаг гэрэл хийж, угсрах ажлыг аймгийн төсвөөс 44,7 сая төгрөгийн хөрөнгөөр аймгийн “Шарга” ХХК шалгаран гүйцэтгэж байна.

Хөдөөгийн 4 багийн төвийн урсгал засварын ажил тус бүр нь ОНХС-н 9,9 сая төгрөгөөр хийгдэж байна.

Өвөлжилтын бэлтгэл ажлын хүрээнд сумын төвд нийт 5000 боодол өвс нөөцлөхөөс 2500 боодол өвс сумын аюулгүйн нөөцөнд хурааж бэлтгээд байна.

Сумын Засаг даргын 2019 оны А/150 дугаар захирамжийн дагуу хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний “Баян намар-2019” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, 4 багийн 18 өрхийн аж ахуй эрхлэгчид оёмол бүтээгдэхүүн, сүү цагаан идээ, төмс хүнсний ногоо, гурилан

бүтээгдэхүүн болон хөдөө аж ахуйн тоног хэрэгсэл зэрэг төрлөөр тус тус оролцож 2,1 сая төгрөгний борлуулалт хийлээ.

ИТХ-ийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдан хэрэгжиж буй малжуулах хөтөлбөрийг 3 дахь жилдээ зохион байгуулж 21 өрхөд тус бүрд нь 50 толгой хонийг хүлээлгэн өгөх ажлыг 5 багт зохион байгууллаа. Уг хөтөлбөрийн эргэлтийн санд цугларах 100 охин хургаас 95-ыг цуглуулан хариуцах малчинд хүлээлгэн өгсөн.

Мөн Хулгар баг дээр хэрэгжиж буй “Тэгш дүүрэн” буюу хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрхөд олгодог 20 ямааг 5 өрхөд хүлээлгэх ажлыг зохион байгууллаа.

2019 оны намрын ургац хураалтаар “Жавхлант шарга хан” хоршоо нь 13 га талбайд төмс 30 тн, лууван 1,5 тн, манжин 1 тн, сонгино 800 кг, өгөрций 1 тн, помидор 800 кг, бусад 200 кг, нийт 35,3 тн ургац хураан авсан байна.

Хууль бус ан, зэвсэг нэгдсэн арга хэмжээний хүрээнд цагаан зээрийн хяналт шалгалтыг хийж хууль бус ан хийсэн 1 иргэнд зөрчлийн тухай хуулийн дагуу 1,3 сая төгрөгийн нөхөн төлбөр, торгуулийн арга хэмжээ авсан ба цагаан зээр агнахыг завдсан 3 иргэний галт зэвсгийг түр хураан авч зөрчил үйлдэхээс сэргийлэн ажилласан.

Түвшинширээ:

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр: ОНХСангийн 40.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Өгөөмөр багийн төвийн барилгыг барьж ашиглалтанд оруулсанаар иргэд төрийн үйлчилгээ, мэдээ мэдээллийг нэг цэгээс шуурхай авах нөхцөл боломж бүрдлээ.

Сумын төвийн ундны усны 2 худагт аймгийн хөрөнгө оруулалт болох 29.0 сая төгрөгөөр цэвэршүүлэх, зөөлрүүлэх “SOFTENER” төхөөрөмж суурилуулах ажлыг “Тот ком сервис ХХК” гүйцэтгэж, хүлээлгэн өгсөн.

Сумын төвийн нэгдсэн хогийн цэгийн далан дотор болон гадуур асгасан хог хаягдлыг түрж цэгцлэх ажилд сумын ЗДТГ-аас 2.5 сая төгрөгийг гарган “Компорт импекс” ХХК– тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна.

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63, 2013 оны 178 тоот зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус сумын 1-р багийн иргэн Д. Батбаатар төв-1 цэцэрлэгт хүрээлэнд 800 гаруй хайлаас мод нөхөн тарилтаар суулгаж услах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Сумын хэмжээнд өнөөдрийн байдлаар ААН, иргэд малчид өөрсдийн нөөц боломжоороо 320 гаруй тн өвс татагдаад байна. Сумын аюулгүйн нөөцөд 20тн өвсийг нөөцлөөд байна.

Түмэнцогт:

Төрийн удирдлагын чиглэлээр: Засаг даргын А\67 дугаар захирамжаар “Түмэн нутгийн соёл” урлагийн наадмыг зохион байгуулахаар удирдамжийг батлуулан 22 байгууллага, 4 багийг нийт 9 баг болгон хуваарилж бэлтгэл ажлыг хангуулж байна.

“Аз жаргалтай гэр бүл” аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд аймгийн ИТХ-ын төлөөлөгч Г.Ганцогт зорилтот бүлгийн 9 өрхөд 5 ханатай иж бүрэн гэр хүлээлгэн өгсөн.

МУ-ын Галын аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилт, аймгийн Засаг даргын А\585 дугаар Аюулгүй байдлыг хангуулах тухай захирамжийн биелэлтийг хангах зорилгоор ЗДТГазар, Цагдаагийн тасаг, Эрэн хайх аврах бүлэг хамтран 17 ААНэгж, байгууллагад үзлэг шалгалт зохион байгуулж галын аюулгүй байдал хангах талаар заавар, зөвлөгөө өгч ажилласан.

Туркийн хамтын ажиллагааны ТИКА сангийн хөрөнгөөр баригдаж буй 50 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажлын явцад хяналт тавих ажлаар сангийн тэргүүн Ибрах, дэд захирал Сэбил, аймгийн Засаг даргын орлогч Б.Ганцогт болон холбогдох албан хаагчид ирж газар дээр нь ажиллалаа.

Аймгийн ИТХурлын тогтоолоор батлагдсан “Аз жаргалтай гэр бүл” дэд хөтөлбөрийн хүрээнд суралцагчдын дунд “Хариу нэхээгүй тус” аян зарлаж 23 бүлгийн 526 суралцагч, 23 анги удирдсан багш нар хамрагдаж ахмад настай 28 иргэнг баярлуулж 560000 гаруй мянган төгрөгний хүнсний болон, эд материалын тусламж үзүүлсэн байна.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Байгаль орчин: Сумын төвийн нэгдсэн хогийн цэгийг цэгцлэх ажлыг “Ус-Дулаан” ОНӨҮГазраар гэрээгээр гүйцэтгүүлж сумын Засаг даргын нөөц сангаас 10 сая төгрөг санхүүжилт олгосон.

Сумын төвийн бохирын карт хаах ажлыг “Ус-Дулаан” ОНӨҮГазраар гүйцэтгүүлж одоогоор 50 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна.

“Ус-Дулаан” ОНӨҮГазар өөрийн хөрөнгөөр 2 дугаар худаг дээр ЕСВ насос 2,6 сая төгрөгөөр, дулааны цех дээр тэжээлийн насос, цахилгааны давтамж хувиргуур 6 сая төгрөгөөр суурилуулсан байна.

Хөдөө аж ахуй: Сүхбаатар хөгжил-2019 үзэсгэлэн худалдаанд 8 төрлөөр оролцож нийт дүнгээр дэд байр эзэлсэн.

Сумын Засаг даргын 2019 оны А163 дугаар захирамжаар Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилганд тугал-1774, хурга-12991, ишиг- 7979 нийт-22744 төл мал хамрагдсан байна.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл

2019 оны 10-р сарын байдлаар хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй 17 ажилгүй ажил хайгчийг бүртгэж 12 иргэнийг ажилд зуучилсан. 2019 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжсэн төсөл хөтөлбөрт хамрагдсан 13 иргэнийг шинээр бий болсон ажлын байрны мэдээлэлд оруулж хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн байна.

Бүлгийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалах арга хэмжээнд хамрагдсан 11 иргэнийг мэдээллийн санд бүртгэж зуучилсан.

Нийгмийн халамжийн үйлчилгээ, хөнгөлөлт тусламж 10 сарын олголт

төрөл	Хүний тоо	Мөнгөн дүн /мян.төгрөг/
Нийгмийн халамжийн тэтгэвэр	41	7308000
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	156	9330520
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт	5	100000
Жирэмсэн хөхүүл эхчүүдийн	26	2209870
Хүнс тэжээлийн дэмжлэг	51	2960000
Цалинтай эхийн тэтгэмж	109	5448390
Алдар цолтой ахмадын тэтгэмж	1	150000

Нийгмийн даатгал: Нийгмийн даатгалын хуулийн өөрчлөлтийн талаарх мэдээллийг иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулж, хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор багуудын засаг дарга нартай эрүүл мэндийн даатгал, сайн дурын даатгалын гэрээ байгуулан ажиллаж байна.

Соёл: Иргэдийг хөдөлгөөний дутагдалаас сэргийлэх зорилгоор Зумба бүжгийн хичээлийг тогтмолжуулан хичээллэж байна.

Соёлын төвийн дэргэдэх бүжгийн дугуйланг хичээллэн тогтмолжуулан бага бүлэг, ахлах бүлэг гэсэн 2 насны ангилалаар монгол ардын бүжгийн дасгал хөдөлгөөнийг зааж байгаа ба дугуйланд бага бүлэгт 30, ахлах бүлэгт 20 сурагчид хамрагдаж байна.

Номын баярын арга хэмжээг Соёлын төв ЕБСтэй хамтран ахлах ангийн сурагчдын дунд “Миний нутгийн тахилгат уулс” гар зургийн уралдаан, “Хүн чулууны хөрөг” бүтээлийн уралдаан зохион байгуулж нийт 30 сурагч хамрагдсан ба 10А анги шалгарсан байна.

ЕБСургууль: Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын ЕБДСургуультай харилцан туршлага солилцох үйл ажиллагааг зохион байгуулж нээлттэй хичээл, гар бөмбөгийн тэмцээн, “Бидний туршлага” уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж 24 багш ажилтан хамрагдсан.

"НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ" зохион байгуулж 90 гаруй эцэг эх, асран хамгаалагч, мэргэжлийн болон анги удирдсан багш нар оролцлоо. Өдөрлөгт оролцогчидод хичээлийн жилийн онцлог мэдээ мэдээллийг өгч, анги удирдсан багш нар маань эцэг эхтэйгээ гэрээ хийх, гар утсанд аппликэшн суулгах, дугуйлан клубын танилцуулга хийх, санал асуулга, өргөдөл гомдол хүлээн авах, эцэг эхийн зөвлөлийг шинэчлэн байгуулсан.

"ЦАХИМ ХЭРЭГЛЭЭГ ЗӨВ БОЛГОЁ" аян өрнүүлж анги бүр дадал хэвшил болгох ажлуудыг зохион байгуулж, өдөр бүр 3 үг зөв бичиж сурах уриалга гарган ажиллаж байна.

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын ЕБС-тай хамтран "Багш сурагчсолилцоо" хөтөлбөрийг хэрэгжүүлж 3 багш, 3 суралцагч туршлага солилцлоо.

"School Police" эцэг эх эргүүлийн үйл ажиллагааг 25 хоногийн хугацаанд 1-2 ангийн суралцагчдын нийт 280 гаруй эцэг эхчүүдийг хамруулан зохион байгууллаа.

"Уран жиргээ – 2019" наадмын 2-р шатанд Монгол хэл, уран зохиолын багш А.Өнөрсайхан 4 суралцагч бэлтгэн оролцож тэргүүн байр-1, дэд байр-1 эзэлсэн амжилт гаргасан байна.

Эрүүл мэндийн төв: 0-5 насны хүүхдүүдэд урьдчилан сэргийлэх үзлэг хийж 166 хүүхэд үзлэгт хамрагдлаа.

Умайн хүзүүний хорт хавдрын эсийн шинжилгээнд 2 иргэн, Хөхний хорт хавдрын эрт илрүүлэгт 35 иргэн, Артерийн гипертензи, чихрийн шижингийн эрт илрүүлэгт 21 иргэн хамрууллаа.

Уулбаян:

Иргэний бүртгэл: 2019 оны 10 сарын байдлаар төрөлт 51, нас баралт 22, гэрлэлт 2, иргэний үнэмлэх сунгалт 59, шинээр олгосон 16, шилжин ирсэн 29 бүртгэгдсэн байна.

Төсөв санхүүгийн чиглэлээр: 9 сарын байдлаар орон нутгийн орлого төлөвлөгөөгөөр 42267.0 мянган төгрөг орохоос 138059.5 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй орлогын төлөвлөгөө 326.6 хувийн биелэлттэй байна.

Байгаль орчин: Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдын хурлын тэргүүлэгчдийн 2018 оны 54 дүгээр тогтоолыг иргэдэд сурталчилж, "Хууль бус ан-Зэвсэг" арга хэмжээг Цагдаагийн хэсэгтэй хамтран зохион байгуулсан.

Сумын Засаг даргын А/139 дүгээр захирамжийн дагуу "Хоггүй цэвэрхэн-Уулбаян сум" уриан дор бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулж 250 иргэн, 21 албан байгууллага, аж ахуй нэгж хамрагдаж 30 тн хогийг хогийг цэвэрлэсэн.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт: Гэр бүлийг дэмжих туршилтийн хөтөлбөрт хамрагдсан 15 өрхөөс судалгаа авсан.

Хамтарсан багаас Эрүүл мэндийн төвтэй хамтран нөхөн үржихүйн эрүүл мэнд, БЗХ өвчний хор уршгийн талаар Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд сургалт зохион байгуулсан.

Боловсрол: Багш нарын дунд "Сурагчдын хүмүүжил, төлөвшил нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох, шийдвэрлэх, арга замыг олох" хэлэлцүүлэг зохион байгуулав. Хэлэлцүүлэгт 25 багш оролцсон байна.

МУ-ын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан Олон улсын өсвөрийн жүдо бөхийн барилдаанд -50кг төрөлд 1 сурагч хүрэл медаль хүртлээ.

Хүүхдийн цэцэрлэг үндсэн сургалтандаа 155, хувилбарт сургалтандаа 55 хүүхэд хамруулж хамран сургалт 80%-тай байна. Мөн 3 гэр барьж тохижуулан номын өргөө, багш хөгжлийн төв болгон тохижууллаа.

Эрүүл мэнд: Урьдчилан сэргийлэх үзлэг-256, идэвхтэй хяналт-7, түргэн тусламжийн дуудлага-36, осол гэмтлийн өвчлөл- 3, урьдчилан сэргийлэх тарилга-39 хүүхэд хамрагдаж нийт 304 хүнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

Хууль, эрхзүйн чиглэлээр: Олон нийтийн мэдээллийн цагаар Сум хөгжүүлэх сангийн журам, Угийн бичиг хөтлөх журмын талаар мэдээлэл өгч, төрийн албан хаагчдын дунд шинээр батлагдсан Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын тогтоол, Төрийн албаны зөвлөлийн тогтоол шийдвэрүүдийн талаар сургалт зохион байгууллаа. Мөн Авлигын эсрэг хууль, Ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар цахимаар олон нийтэд мэдээлэл өгсөн.

Халзан:

а/ Сумын ИТХ-ын ажлын чиглэлээр: Аймгийн ИТХ-аас ажлын хэсэг ирж Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хийж, заавар зөвлөмж өгч ажилласан.

Мөн ИТХ-ын дэргэд дэх дэд бүтэц, хууль зүйн хорооноос шинээр баригдаж буй хүүхдийн цэцэрлэгийн барилгын явц байдалтай танилцаж хөндлөнгийн хяналт хийж ажилласан.

б/ Тамгын газар төрийн удирдлагын ажлын чиглэлээр: Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга нар 1, 2,3-р багуудад ажиллан өвөлжилтийн бэлтгэл ажилтай танилцан, иргэдийн санал хүсэлтийг сонссон ажиллав.

БСШУСЯ-ны сайд Ё.Баатарбилэг нийт 16 хүний бүрэлдэхүүнтэйгээр тус суманд ажиллаж Шинээр баригдаж буй Соёлын төв, Хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажилтай танилцлаа.

“Иргэн төвтэй төрийн үйлчилгээ жил”-ийн хүрээнд “Иргэн төвтэй төрийн үйлчилгээ” өдөрлөгийг Аймгийн ИТХ-ын төлөөлөгч Г.Мөнхзаяа болон ЗДТГ хамтран зохион байгууллаа. Тус өдөрлөгөөр Аймгийн нэгдсэн эмнэлэгийн нарийн мэргэжлийн 12 эмч нар ирж ард иргэдэд үзлэг шинжилгээг хийв. Мөн Ахмад настны тухай хууль болон Өсвөр насны хүүхдүүдэд зөв хүмүүжил төлөвшил олгох сургалтуудыг ЕБС дээр зохион байгууллаа.

Санхүү, эдийн засгийн бодлогын хүрээнд: Энэ сард аймгаас авах санхүүгийн дэмжлэгээр 24600000 төгрөг авч орон нутгийн төсөвт байгууллагуудад 27666600 төгрөгийн санхүүжилтийг олголоо.

Хууль, эрх зүйн хүрээнд: Газрын даамал газар зохион байгуулалт болон бэлчээрийн даацын мэдээллийг сонсгол мэдээллийн цагаар ЗДТГ-ын 20 албан хаагчдад, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмээр ЗДТГ-ын сонсгол мэдээллийн цаг дээр ХШҮДАХ мэргэжилтэн, байгууллагын дарга эрхлэгч нар болон ЗДТГ-ын мэргэжилтнүүдэд Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол болон түүнийг даган гарсан аймгийн Засаг даргын А/612 дугаар захирамжаар, Улсын бүртгэгч Улсын бүртгэлийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн талаар мэдээлэл сургалт тус тус хийж ажиллав.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр

Мал эмнэлэгийн чиглэлээр: Бруцеллёз болон цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад төл малыг бүрэн хамруулаад байна.

ВИ ТИ НЕТ төрийн бус байгууллага, мал эмнэлэг, ХХМЭ хамтран “Хайрын бэлэг” малжуулах төслийг хамтран хэрэгжүүлж 8 иргэнд 24 хонь тусламжаар өглөө.

Хөдөө аж ахуйн чиглэлээр : Өвөлжөө, хаваржааны доорх газрыг эзэмшүүлэх ажлын бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. 15 цэгт фотомониторингийн судалгааг хийхэд бэлчээрийн даац 70 хувьтай, ургамалын төрөл 24 байна.

“Сүхбаатар хөгжил-2019” арга хэмжээний хүрээнд сум нийт дүнгээрээ тэргүүн байр “Гран при номинаци”-д шалгарч шилжин явах цомын эзэд боллоо.

ЖДҮйлдвэр, Сум хөгжүүлэх сангийн чиглэлээр: 2019 оны 09-р сарын 24-ны байдлаар нийт 21 зээлдэгч байгаагаас 2019 оны 10 сарын зээлийн эргэн төлөлтийн орлого 13 хүнээс 10,349,468 мянган төгрөгний орлого Сум хөгжүүлэх сангийн дансанд төвлөрүүлсэн байна.

Байгаль орчны чиглэлээр: Нийтийн эзэмшлийн талбайн хог хаягдлыг албан газруудаар цэвэрлүүлж нэгдсэн хогийн цэгт 4 тонн хогийг төвлөрүүлэн ажиллав.

Мод тарих үндэсний өдрийг тохиолдуулан албан газар, аж ахуй нэгжүүд өөрийн эзэмшлийн талбай дахь модондоо цэнэг усалгааг хийв.

Эрдэнэцагаан:

Төрийн удирдлагын ажлын чиглэлээр: Төрийн байгууллагын нээлттэй хаалганы өдөрлөг 10 дугаар сарын 11-ний өдөр болж өнгөрлөө. Тус өдөрлөгөөр Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын тамгын газар, Цагдаагийн тасаг, Онцгой байдлын аврах гал унтраах 47-р анги хамтран зохион байгуулж төрийн үйлчилгээг ард иргэдэд хүргэж ажиллалаа. Нээлттэй хаалганы өдөрлөгөөр 229 иргэн үйлчлүүлж 14 чиглэлээр 422 иргэнд /давхардсан тоогоор/ төрийн үйлчилгээг үзүүлж, албан хаагчид 49 нэр төрлийн 2047 ширхэг гарын авлага, тараах материалыг бэлтгэж иргэдэд тарааж ажиллалаа. Өдөрлөгийн үеэр 15 иргэнээс санал

хүсэлт, 6 иргэний өргөдөлийг хүлээн авч холбогдох албан хаагчид цохон ажиллаж байна. Төрийн үйлчилгээ үзүүлж буй албан хаагчдийг үнэлэх сэтгэл ханамжийн судалгааг тухайн өдөр 101 иргэнээс авсаныг дүгнэж үзэхэд ерөнхий үнэлгээгээр 71 хувьтай үнэлэгдсэн байна.

Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Ерөнхий боловсролын сургууль: “Эцэг эх-сурагч” нэг өдөрлөгийг зохион байгууллаа.

“Өсвөр үеийн шүдний өвчлөлийг бууруулахад олон нийтийн оролцоо” дэд төслийн хүрээнд сургуулийн эмч, анги удирдсан багш нар хамтран 6-12 ангийн сурагчидыг амны хөндийн үзлэгт бүрэн хамрууллаа.

“Охидын эрхийг хамгаалах өдөр”-ийн хүрээнд:

- Ахлах ангийн охидын дунд “Охид бид Монголын ирээдүй” сэдэвт чөлөөт ярилцлага зохион байгуулж 9-12 ангийн 67 охид,
- Дунд ангийн охидын дунд “Охид бидний хүсэл мөрөөдөл” сэдэвт чөлөөт ярилцлага зохион байгуулж 6-8-р ангийн 125 охид тус тус оролцлоо.

Мөн бага анги буюу 1-5 р ангийн охидын дунд “Хөгжөөнт буухиа” тэмцээн явуулж 2-р ангийн охид, дунд ангийн хөгүүдийн дунд “Охид” шүлгийн уралдаан зохион байгуулсан байна.

Соёлын төв: Егүзэр хутагт хатагины хар сүлд тахилгын өргөөнд үзмэрийн баяжилт хийх зорилгоор ард иргэдийн гар дээрх үзмэрийг худалдаж авах саналыг нээлттэй байдлаар олон нийтийн сүлжээнд байршууллаа.

Энэ сард номын сангаар 36 хүн үйлчлүүлж 96 ширхэг номоор үйлчилсэн байна.

Нийгмийн даатгал: НДЕГ-аас зарласан “Даатгуулагч таньд урьдчилан зөвлөө- тусалъя” сэдэвт аяны хүрээнд эрэгтэй 1959,1960 онууд, эмэгтэй 1965,1964 онуудад тэтгэвэрт гарах иргэдийн нэрс ирж үүний дагуу 8 иргэнд зөвлөгөө өгч, үйлчлүүлэгчээс сэтгэл ханамжийн судалгаа авч дээд шатны байгууллагад тайланг хүргүүллээ.

Нийгмийн даатгалын дэвтэрийн бичилт, тушаалд хяналт шалгалт хийх аян зарлагдсанб дагуу 2-р цэцэрлэг, ЗДТГ, Соёлын төв, ИТХ-ын нийт 57 ажилчдын дэвтэрт хяналт шалгалт хийж гарсан зөрчил дутагдалыг арилгуулах үүднээс улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлэх арга хэмжээг аван ажиллаж байна.

Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд

Хөдөө аж ахуй: Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэл аяны хүрээнд Дарьганга суманд зохион байгуулагдсан аймгийн Өмнөд бүсийн тогооч, худалдагч нарийн тэмцээнд 15 хүний бүрэлдэхүүнтэй оролцож сумаараа ТЭРГҮҮН байр эзэлсэн.

Тамхины зөвшөөрөл 2 аж ахуйн нэгж сунгалт хийлгэж авсан ба төсөвт 200,000 төгрөг төвлөрүүлсэн.

Оргих төгөлдөр ХХК нь сумын орон нутаг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 9 худаг гаргаад байна.

ХХААХҮЯ-ны сайдын тушаал, аймгийн Засаг даргын А/503 дугаар захирамж, сумын Засаг даргын А/103 дугаар захирамжийг тус тус үндэслэн малын генетик нөөцийг тодорхойлох үнэлэх ажлыг Дарьганга, Асгат, Эрдэнэцагаан, Онгон, Наран, зэрэг сумдын мал зүйч нартай хамтран зохион байгуулж бүгд 13800 мал буюу бод-880 бог-12920 малд ангилалт үзлэг хийлээ. мрагдсан.

2019 оны 10 дугаар сарын 19-ны өдөр Бүх нийтийн хог цэвэрлэгээний өдрийг зохион байгуулж 6 албан байгууллага, 28 аж ахуй нэгжийн 625 хүн хамрагдаж сумын төвийн нийтийн талбай болон ойр орчмын хогийг цэвэрлэж 25 тн хогийг нэгдсэн хогийн цэгрүү зөөвөрлөж ажиллалаа.

Төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажлыг шалгах үүднээс сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг томилогдож байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл ажлыг шалгаж ажилласан бөгөөд гарсан зөрчил хүндрэл байхгүй гэсэн мэдээллийг өгсөн байна.

Малчид иргэд 1150 тн өвс, Сумын нөөцөд 100 тн өвс нөөцлөн ажиллаж байна.

Дэд бүтэц: Сумын төвд Улсын төсвийн хөрөнгө оруулалттай Цэцэрлэгийн барилга зогсонги байдалтай, Ерөнхий боловсролын сургуулийн барилгын ажил эхэлж байна. 2019 ОНХС-н хөрөнгөөр хийгдэж буй цэцэрлэгт хүрээлэнгийн тохижолтын ажил 80 хувьтай явагдаж байна.

ЕБСургуулийн сантехникийн асуудалтай, Соёлын төвийн дээврээс бага зэрэг дусаал гоожсон түр зуурын арга хэмжээг авсан, Эрүүл мэндийн төв ажилтны амралтын байр халаалтгүй засвар үйлчилгээ хийгдээгүй зэрэг асуудлыг гаргасаныг холбогдох удирдлагуудад мэдээллэж ажиллалаа.